

“МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ДЭЛХИЙ ДАХИНАА 2006” СУДАЛГАА

“PRIVACY INTERNATIONAL” БАЙГУУЛЛАГА ДАВИД БАНИСАР

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ: ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ГАРЧ БУЙ ХӨГЖИЛ ДЭВШИЛ

Оршил

Мэдээллийн эрх чөлөө хүн бүрт байх ёстой чухал эрх юм. Энэхүү эрх нь хувь хүмүүс болон аливаа бүлэг хүмүүс өөрсдийн эрх ашгаа хамгаалах нөхцлийг бүрдүүлж өгдөг. Аливаа дарамт, шахалт, буруу удирдлага, авилгалын эсрэг тэмцэх зэрэг үйл ажиллагаанд мэдээллийн эрх чөлөө чухал хэрэглүүр болдог. Мөн түүнчлэн нээлттэй засаглал, шийдвэр гаргалтын явц дахь ил тод байдал нь иргэдийн засгийн газарт итгэх итгэлийг нэмэгдүүлдэг нь засгийн газарт өөрт нь их ашигтай байдаг.

МЭЧ (Мэдээллийн Эрх Чөлөө) олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөж, цар хүрээ нь улам нэмэгдэж байна. Олон улсын хооронд байгуулсан олон тооны хамтын гэрээ, хэлцэл, мэдэгдэлүүд аливаа бүс нутаг, засгийн газрыг энэхүү МЭЧ хуулийг хүлээн зөвшөөрөхөд хүргэх эсвэл урамшуулан дэмжих нөхцлийг бүрдүүлж байна. Энэ нь олон улсын тавцан дээр үр дүнгээ өгч эхлээд байна. Одоогийн байдлаар 70 гаруй улс Мэдээллийн Эрх Чөлөөний Актыг хүлээн зөвшөөрч төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг авах боломжийг бий болгоод байгаа бөгөөд өөр 50 орон энэхүү эрхийг нийтэд хүргэх талаар ажиллаж байна.

Цөөн хэдэн орон энэ эрхийг Үндсэн хуулиндаа тусгаж өгсөн эсвэл нэмэлт маягаар оруулжээ. Ихэнх орнууд мэдээлэл хамгаалах хууль буюу иргэд өөрсөдтэйгээ холбоотой мэдээллийг засгийн газар эсвэл хувийн хэвшлийн мэдээллийн сангаас авах эрх, байгаль орчин, эрүүл мэнд, засгийн газрын худалдан авалт, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудалтай холбоотой мэдээллийг авах эрх бүхий хязгаарлагдмал хуулийн орчинг бүрдүүлсэн байна.

Хэдийгээр МЭЧ бий болоод 200 гаруй жил болсон боловч өнөөг хүртэл хөгжлийнхөө шатнаас гарч хараахан амжаагүй байна. МЭЧ -тэй холбоотой хуулиудын талаас илүү хувь нь зөвхөн сүүлийн 10 жилд л шинээр бий болсон юм. Ил тод, нээлттэй нийгэм бий болгох нь төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон олон улсын зээлдүүлэгч нараас ихээхэн шалтгаалах болно. Шинээр бий болсон хуулиудын ихэнх нь аливаа саад тотгоргүйгээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Гэсэн хэдий ч жинхэнэ нээлттэй, ил тод төрийг байгуулахын тулд асар их чармайлт гаргах шаардлагатай байна. Аливаа зүйлийг нууцладаг уламжлалт хандлага олон улс оронд бөх бат оршсоор байна. Батлагдан гарсан хуулиудын ихэнх нь өнгөн дээрээ МЭЧ-ийг дэмжиж байгаа мэт харагдавч бодит амьдрал дээр уг хуулиуд нь хангалтгүй байна. Зарим орнуудад хууль нь байгаа боловч хэрэгжүүлэхгүй эсвэл эрэлт хэрэгцээ байхгүй учраас МЭЧ идэвхжихгүй байх хандлага байна. Бусад орнуудад МЭЧ-ээс чөлөөлөх заалтын тоо, мэдээлэл авах төлбөрийг төрөөс хэт өндрөөр тавьж иргэдийн эрх ашгийг хөндөж байна. Дээр үед батлагдан гарсан хуучин хуулиудыг технологи, нийгмийн орчин үеийн хөгжилтэй уялдуулан өөрчлөх шаардлага ч бас ажиглагдлаа. Дэлхий дахиныг хамарсан терроризмтэй тэмцэхтэй уялдан гарсан шинэ хуулиуд нь мэдээлэл авах

боломжийг мөн адил хязгаарлах хандлагатай байна. Үндэсний засаг захиргааны чиг үүргийг гүйцэтгэж буй олон улсын байгууллагууд мэдээллийн эрхтэй холбоотой хуулиудыг даган мөрдөхгүй байх тохиолдол бас байна.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ҮР АШИГ

Ардчилсан оролцоо ба ойлголт

МЭЧ -д олон нийтийн оролцоо маш чухал үүрэгтэй байдаг. Ардчилал нь ард түмний нэгдсэн хүсэл эрмэлзлэл дээр бий болдог, тэр хүсэл эрмэлзлэлийн дагуу төр нь өөрийн үйл ажиллагаагаа ард түмэндээ танилцуулдаг, засаглалын үйл ажиллагаанд ард түмэн оролцох эрхийг нь хүлээн зөвшөөрдөг зарчим дээр тулгуурладаг юм. Зөвхөн, төрийн бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжтой тэр л үед ард түмэн ардчилалын үйл явцад үнэн бодит хэлбэрээр оролцох боломжтой болно. Аливаа шийдвэр гаргасан шалтгаан нөхцөл байдлыг ард олонд таниулах нь нийгмийн зүгээс дэмжлэг хүлээх, үл ойлголцох байдал болон бухимдалыг бууруулах давуу талтай. Мөн түүнчлэн парламентийн бие даасан гишүүн аливаа нэгэн зүйлийг хянах, шалгах нөхцөл боломж улам сайжрах болно. Төрийн гаргах гэж байгаа шийдвэр нь ил тод байх юм бол төрд итгэх итгэл улам нэмэгдэнэ. 1982 оны “Албан Ёсны Мэдээллийн Акт” -ыг батлан гаргасан Шинэ Зеланд улсын Комисс “ иргэдийг мэдээллийн хангалттай эх сурвалжаар хангах нь нийгмийн зөрчилдөөнтэй үзэл бодлууд, эсвэл улс төрийн маргааныг нэгмөсөн дуусгавар болгоно гэсэн үг биш. Харин энэхүү мэдээллийг иргэдэд (өөрчлөлттэй холбоотой) аль нэг талын эрх ашгийг илүүд тавихгүйгээр эн тэнцүү хүргэвэл маргалдагч талуудын үзэл бодлын зөрүүг багасгаж, хэрэгжүүлэх бодлогын үр ашгийг нэмэгдүүлж тухайн системд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх болно” хэмээн цохон тэмдэглэжээ.

Бусад Эрхийг Хамгаалах

МЭЧ-ний тухай хууль нь эдийн засгийн болон улс төрийн бусад олон эрхийн хэрэгжилтийг сайжруулдаг. Энэтхэгт МЭЧ-ийн хуулийг ашиглан ядуучуудад төрөөс олгодог хоолыг түгээдэг газрууд хоолоо тогтоосон хэмжээний дагуу олгодоггүй болохыг нь илрүүлжээ. Ингэснээр хоол түгээх системд нааштай өөрчлөлт гарч, хоол түгээдэг цэгүүд төрөөс хөнгөлөлт эдлэн хоол түгээж, ядуучууд ч гэсэн төрөөс олгосон хоолоо хэмжээнд нь авч чаддаг болжээ. Мөн бусад газрууд МЭЧ-ийг ашиглан ажлын байр бий болгох, зам барилга гэх мэт удаан хугацааны үйл ажиллагаануудад хандах төрийн албан хаагчдын хандлагыг өөрчлөх боллоо. Тайландад, элит сургуульд орох гэсэн охиныг нь хүлээн аваагүй сургуулийн шалгалтын дүнгийн жагсаалтыг эх нь шаарджээ. Энэхүү шаардлагыг нь биелүүлээгүй учир эх нь Тайландын Мэдээллийн Комисс болон шүүхэд хандсан аж. Эцэст нь тэр эх шалгалтын дүнгийн жагсаалтыг хуулийн дагуу аван үзэхэд, нөлөөтэй чинээлэг хүмүүсийн хүүхдүүд шалгалтандаа доогуур оноо авсан ч уг сургуульд орсон болох нь тогтоогджээ. Үүнээс үүдэн Тайландын Улсын Зөвлөл бүх сургуулиуд хүүхдүүдийг зөвхөн мэдлэг чадвар дээр нь үндэслэн элсүүлэн авч байх шийдвэр гаргасан байна. АНУ д гэхэд л МЭЧ-г төрийн зөвшөөрөлтэй эрүүдэн шүүх, хууль бусаар тагнан мөрдөх үйл ажиллагааг илрүүлэхэд ашигласан байна.

Мэдээлэл Хамгаалах хууль / Data Protection law/ болон зарим МЭЧ хуулиар төрийн болон хувийн байгууллагуудад байгаа мэдээллийг хувь хүмүүс авах боломжийг бий болгосон байдаг. Хүмүүс ингэж өөрсдийн талаархи мэдээлэлтэй танилцдаг болсноор хуучин эсвэл буруу мэдээллийг залруулах боломжтой болдог юм. Мөн түүнчлэн хүмүүс ямар үйлчилгээ, тэтгэлэгт хамрагдах боломжтой эсэх, заагдсан хэмжээнд нь тэдгээр үйлчилгээг хүртэж байгаа эсэхээ мэдэж авах боломжтой болдог. Өмнөд Африк улсад Мэдээллийн хүртээмжийг эрчимжүүлэх актын хувь хүн мэдээлэл авах тухай зүйлд заасны дагуу хувь хүмүүс банк зээлийн өргөдөлд зээл өгөөгүй шалтгаан, хувьцаа эзэмшдэг хар арьст хүмүүс хувийн компаниудын талаар мэдээлэл авах, Апартейдийн дэглэмийн үед хэрэглээний хувийн компаниуд ямар үйл ажиллагаа явуулж байсан

тухай мэдээлэл хайсан түүхч, аль нэг төслийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх хор нөлөөний судалгааны талаархи мэдээллийг байгаль хамгаалах бүлгүүд олж авч байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах

МЭЧ хууль төрийн үйл ажиллагааг мөн адил сайжруулдаг. Ард түмэнд гаргасан шийдвэрийнхээ тухай мэдээлэл зайлшгүй хүргэх ёстой болдог учраас төр тухайн шийдвэрээ аль болох бодит байдал дээр тулгуурлан, үнэн зөвөөр гаргахад хүрдэг. 1997 онд байгуулагдсан Шинэ Зеландын Хуулийн Комисс “ бодлогын чанартай шийдвэр МЭЧ Актын дагуу удалгүй олон түмний өмнө дэлгэгдэх болно гэдгийг мэдэж байх нь бидний үзэж байгаагаар тухайн шийдвэрийн чанар, ил тод байдалд сайн, эерэг нөлөө үзүүлнэ гэж бодож байна” тэмдэглэжээ. Австралийн Хуулийн Шинэчлэлтийн Комисс болон Удирдлагын Хяналтын Зөвлөлийн цохон тэмдэглэсний дагуу “энэ Акт нь [МЭЧ] засгийн газрын агентлагуудын шийдвэр гаргах арга хэлбэр, мэдээлэл бүртгэх үйл явцад мэдэгдэхүйц нөлөө үзүүлээ... [МЭЧ] шийдвэр гаргалтыг үнэн бодит нөхцөл байдал дээр тулгуурлан хийх, шийдвэр гаргалтын үйл явцыг нарийвчлан бүртгэхийг шийдвэр гаргагч нарт байнга сануулах болжээ. МЭЧ-ийн хуулийн дагуу, тэдний гаргасан шийдвэр нь олон нийтэд мэдээлэгдэж, хэлэлцүүлэгдэх болно гэдгээ мэдэж байх нь төрийн байгууллагуудын үйл ажиллагааг байнгын эмх журамтай байлгах болно” гэжээ.

Гэрээ байгуулах болон бусад санхүүгийн үйл ажиллагааг заавал баримтжуулан бүртгэж байдаг учраас МЭЧ нь авилгалын эсрэг тэмцэх томоохон хэрэгсэл болдог. Энэтхэгт, нийгмийн эрхийн төлөө тэмцэгч нар МЭЧ ийн дагуу аль нэгэн төсөл хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний мөнгө зарцуулах ёстой байсан гэдгийг гэрээнээс нь мэдэн дараа нь нутгийн хүмүүсээс чухам хэдий хэр мөнгө төлбөрийн журмаар авсан гэдгийг асууж харьцуулдаг болжээ. Үүний үр дүнд, дуусгалгүй орхисон төслийн улмаас бодитой төлсөн төлбөрийн хэмжээ гэрээнд заасан төлбөрийн хэмжээнээс зөрөөтэй байх эсвэл нас барсан хүмүүсийн нэр дээр хүртэл төслийн мөнгийг зарцуулж байсныг илрүүлжээ.

Өмнө учирсан үр дагаврыг сэргээх

Ардчилал руу шинээр шилжиж байгаа улс орнуудын хувьд МЭЧ нь өнгөрснөө хүлээн зөвшөөрч, хохирогчдын тухай нийгэм болон тэдгээрийн ар гэрийнхэнд мэдээлж, юу болоод өнгөрсөн тухай ойлгоход дэм болдог. Сүүлийн жилүүдэд бий болсон эсвэл шинэчлэн найруулсан Үндсэн хууль бүр төрөөс мэдээлэл авах хувь хүний эрхийг суурь эрх эсвэл иргэний эрх олгон тусгах боллоо.

Зөвлөлт Холбоот Улс задран унасны дараа Төв болон Зүүн Европын орнууд дотоод яамны баримт бичгүүдтэй танилцах хууль гаргаж байсан юм. Зарим орнууд нь хувь хүн өөр дээр нь ямар баримт (хувийн хэрэг) бүрдүүлж байсныг мэдэх боломжтой хууль гаргаж байсан бол зарим орнууд тусгай комисс гарган дотоод яамны мэдээлэгч байсан хүмүүсийг засгийн газарт оруулахгүй байх эсвэл олон нийтэд зарлах ажил хийж байжээ. 2002 онд Мексикийн ерөнхийлөгч Фокс, хүний эрх зөрчиж байсантай холбоотой урьдын бүхий л баримтуудыг ил болгож, гэр бүлийн гишүүн эсвэл хайртай нэгнийгээ сураггүй алдсан хүмүүст тэднийхээ талаархи мэдээлэл олж авах боломж олгожээ. АНУ-д Үндэсний Аюулгүй байдлын Архивын зүгээс АНУ –ын засгийн газарт хүсэлт гарган Мексик, Чили, Перу улсуудад гарсан хүний эрхийг зөрчсөн тохиолдлуудын талаархи хэдэн мянган хэрэгтэй холбоотой материалуудыг тэдгээр орнуудын Цагаатгах Комиссуудад өгсөн байна.

МЭЧ-ийн ОЛОН УЛСЫН ЭХ СУРВАЛЖ

Улс үндэстэнгүүдийг мэдээллийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, МЭЧ ийн хууль гаргахыг шахсан, дэмжлэг үзүүлсэн олон улсын гэрээ хэлэлцээр, зөвшилцөл, хөтөлбөр болон бусад мэдэгдлүүдийн хэмжээ өссөөр байна. Ялангуяа авилгалын эсрэг тэмцэх явдалтай холбогдон, иргэдийг мэдээллээр хангах хуулийг бий болгох шаардлага улам өсөж байна. Байгаль орчныг хамгаалах гэрээ хэлэлцээрүүд мөн адил иргэдийг мэдээллэл авах эрхээр хангахыг шаарддаг болсон. Энэ нь улс орнуудыг байгаль орчинтой холбоотой мэдээллэл болон бусад ерөнхий мэдээллийг олон нийтэд хүргэхэд нөлөөлсөн юм. Мөн түүнчлэн бүс нутгийн болон олон улсын түвшинд хүний эрхийг хамгаалахад МЭЧ ийн үүрэг ихээхэн өсөж байна.

Авилгалын Эсрэг НҮБ-ын Конвенци

Авилгалын Эсрэг НҮБ-ын Конвенци 2003 оны 10 сард НҮБ-ын Ерөнхий Зөвлөлөөр батлагдаж 2005 оны 12 сард 30 орны дэмжлэгтэйгээр хүчин төгөлдөр болсон билээ¹. Энэхүү Конвенцийн 10-р зүйл “Олон Нийтэд Мэдээлэх” хэсэг нь олон нийтийн мэдээллэл авах эрхийг авилгалтай тэмцэх хэрэгсэл болгон ашиглахыг улс орнуудад уриалсан байдаг:

Авилгалын эсрэг тэмцэхдээ, тухайн Улс нь, өөрийн улс орны хуулийн үндсэн ёс журмын дагуу, шаардлагатай бол, төрийн үйл ажиллагааг улам ил тод нээлттэй болгохын тулд, төрийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцтай уялдуулан авах арга хэмжээнүүд дараахи зүйлсийг оруулж болох бөгөөд үүнд:

(а) Шаардлагатай бол, нийгмийн гишүүд төрийн байгууллага, үйл ажиллагаа, шийдвэр гаргах явцтай холбогдох мэдээллийг хувийн нууц болон хувийн мэдээллээ хамгаалахын тулд, мөн нийгмийн гишүүдийн санааг зовоож байгаа шийдвэр, хуулийн үйлдэлтэй холбоотой мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх журам, тогтоомжийг боловсруулан хэрэгжүүлэх;

(b) Шаардлагатай бол, нөлөө бүхий шийвэр гаргагч нарт иргэд хүрэх(уулзах, холбоо барих) тухай журмыг энгийн болгох

(c) Мэдээллийг түгээх, түүндээ төрийн байгууллагууд авилгалд өртөх эрсдийн талаархи тайлан мэдээллийг багтаах.

Мөн түүнчлэн, 13 дугаар зүйл буюу “Нийгмийн Оролцоо” хэсэгт:

Оролцогч Улс орон бүр өөрийн орны хуулийн үндсэн ёс журмын хүрээнд, төрийн байгууллагаас бусад хувь хүмүүс болон бүлгүүд буюу иргэний нийгэм, төрийн бус байгууллагууд мөн олон нийтийн байгууллагуудыг ашиглан авилгалтай тэмцэх, авилгал, түүний хор хөнөөл, нийгэмд авилгал байгаа талаар нийгмийг соён гэгээрүүлэх хэмээн заасан байдаг. Энэхүү оролцоог доорхи арга замуудаар бэхжүүлэх боломжтой:

(а) Нээлттэй байдлыг улам ил тод болгох мөн шийдвэр гаргах явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,

(b) Иргэд мэдээллэл авах боломжийг сайжруулах;

Энэхүү тайланг бичих үед энэ Конвенцэд 140 орон гарын үсэг зурж 60 гаруй орон хүлээн зөвшөөрсөн байлаа² Тэдгээрээс 20 гаруй нь өөрийн үндэсний МЭЧ хуультай билээ.

Нэгдсэн Үндэсний Байгууллага, Хүний Эрх

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Олон Улсын Иргэний болон Улс төрийн Гэрээний 19 дүгээр зүйл дээр хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллэл хүлээн авах болон хайх эрхтэй хэмээн заасан

¹ Авилгалын Эсрэг НҮБ-ын Конвенци. http://www.unodc.org/en/crime_convention_corruption.html

² http://www.unodc.org/unodc/en/crime_signatures_corruption.html

байдаг³. Мэдээлэл хайх эрх гэдэгт мэдээллийн эрх чөлөөг хавсруулан хүлээн зөвшөөрөх явдал улам бүр өргөжсөөр байна⁴.

Үзэл Бодол болон Үзэл Бодлоо Чөлөөтэй Илэрхийлэх Эрх Чөлөөний тухай НҮБ-ийн Тусгай Мэдээлэл (Рапорт) мэдээллийн эрх чөлөө нь өөрөө хүний эрх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн аль алиных нь чухал хэсэг байх болно хэмээн тунхаглав⁵. Тусгай Мэдээллийн улс орнуудыг МЭЧ хууль дагаж мөрдөхийг уриалсан уриалгад Америкийн Улсуудын Байгууллага болон Европын Аюулгүй байдал Хамтын Ажиллагааны Байгууллагууд мөн адил нэгдэн оржээ.⁶

Сүүлийн жилүүдэд аливаа улс оронд шинжилгээ хийхдээ Хүний Эрхийн Хороо мэдээллийн эрх чөлөөний талаархи анализийг оруулдаг болжээ. Хүний Эрхийн Хорооноос Их Британи болон Узбекистан улсуудад, улсын нууцын тухай хуулийн хамрах хүрээг багасгах хэрэгтэй хэмээн зөвлөж, энэ нь 19 дүгээр зүйлийг зөрчиж байна хэмээн сануулжээ⁷.

Риогийн тунхаглал/UNECSE Байгаль Орчинтой Холбоотой Мэдээллийг Түгээх Конвенци

1992 оны НҮБ-ын Байгаль орчин ба Хөгжил (Дэлхийн Чуулга) хуралдаан дээр Байгаль орчин ба Хөгжлийн талаархи Риогийн Тунхаглал улс орнуудыг мэдээлэл авах боломж, нөхцлийг сайжруулахыг уриалжээ. 10 дугаар зарчимд дурдахдаа:

Байгаль орчинтой холбоотой асуудлыг шийдвэрлэх хамгийн тохиромжтой арга нь бүх түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм.

Тухайн улсын хувьд, хүн бүр төрийн эрхийн дагуу байгаль орчны талаар мэдээлэл авах эрхтэй байх, хор хөнөөлтэй материал болон олон нийтийн эзэмшлийн газар, хөрөнгө , орчинд явагдаж буй үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авах улмаар шийдвэр гаргалтын явцад оролцох эрхтэй байх нь зохистой.

Тухайн Улс нь мэдээллийг чөлөөтэй түгээснээр олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд шууд оролцох, иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үүрэгтэй. Нөхөн сэргээлт, нөхөн олговор бусад зүйлээр хуулийн болон засаглалын үйл ажиллагаанд хандах гэсэн иргэдэд хууль зүйн нөхцөл байдлыг нь бүрэн хангаж өгөх үүрэгтэй⁸.

1991 оноос эхлэн НҮБ-ын Европын Эдийн Засгийн Комисс (UNECSE) байгаль орчинтой холбоотой мэдээлэл авах боломж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ажилгааг эрчимтэй хэрэгжүүлж эхэлсэн. 1998 оны 6 сард батлагдсан UNECSE-ийн Мэдээлэл түгээх, Байгаль орчинтой холбоотой асуудлаар Шүүхэд Хандах Боломж, Шийдвэр гаргах Явцад Оролцох Иргэдийн Оролцоог Нэмэгдүүлэх

³ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал. Ерөнхий Зөвлөлийн шийдвэр 217 А (III) 1948 оны 12 сарын 10; Олон Улсын Иргэний болон Улс төрийн Гэрээ, Ерөнхий Зөвлөлийн шийдвэр 2200А (XXI) 1966 оны 12 сарын 16 http://www.unhchr.ch/html/menu3/b/a_ccpr.htm

⁴ МЭЧ- хүний эрх хамгаалах дэлгэрэнгүй анализийг Тоби Мендель “Мэдээллийн эрх Чөлөө Хүний эрхийг олон улсын түвшинд хамгаалах нь” “Comparative Media Law” Сэтгүүл, No. 1, 2003 оны 1-6 сарыг үзнэ үү. <http://www.juridicas.unam.mx/publica/rev/comlawj/cont/1/cts/cts3.htm>

⁵ Абид Хуссейн, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, түүнийг хамгаалах болон дэмжих Тусгай Мэдээлэл, НҮБ-ын Хорооны 1999/36 шийдвэр, НҮБ-ын Хүний Эрхийн Тухай 2000 оны 1 сарын 18-ны 56 дугаархи Хурал E/CN.4/2000/63

⁶ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөний тухай НҮБ-ын Тусгай Мэдээлэл, Европын Аюулгүй байдал Хамтын Ажиллагааны Хорооны Төлөөлөгч, Америкийн Улсуудын Тусгай Мэдээллийн хамтран гаргасан Хамтын Тунхаглал, 2004 оны 12 сарын 6.

⁷ Хүний Эрхийн Хорооны Ажиглалтын Дүгнэлт: Узбекистан 2001 он 4 сар 26. CCPR/CO/71/UZB; Хүний Эрхийн Хорооны Ажиглалтын Дүгнэлт: Их Британийн Эзэнт Гүрэн болон Хойд Ирланд 2001/05/11. CCPR/CO/73/UK, CCPR/CO/73/UKOT.

⁸ Риогийн Байгаль Орчин Хөгжлийн Тунхаглал, Рио Де Жанеро , 1992 оны 6 сарын 3-14. <http://www.un.org/documents/ga/conf151/aconf15126-1annex1.htm>

Конвенци (Аархуусын Конвенци) 2001 оны 10 сараас бүрэн төгс хэрэгжиж эхэлсэн⁹. Конвенцийн 4-р зүйлд заасны дагуу засгийн газрууд иргэд байгаль орчинтой холбоотой мэдээллийг (мөн баримт бичгүүдийг оролцуулан) засгийн газрын байгууллагуудаас шаардах, авах эрхийг нь хангасан хуулийг батлан хэрэгжүүлэхийг шаарджээ. Байгаль орчинтой холбоотой мэдээлэлд тухайн орчин дахь элементүүдийн нөхцөл байдлын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, тухайн орчингийн нөхцөл байдлад нөлөөлж болох хүчин зүйлүүд, тухайн орчин дахь хүний эрүүл мэнд аюулгүй байдал, хүний амьдрах нөхцөл, байгаль орчны нөлөөлөлд өртөх соёлын дурсгал болон барилга байгууламжуудын талаархи мэдээлэл орох болно.

Улс орон өөрийн хуулиндаа заавал оруулах журмын хэмжигдэхүүнүүдийг Конвенци тогтоож өгсөн. Иргэд мэдээлэл шаардахдаа тухайн мэдээллийг шаардах хууль зүйн үндэслэлээ батлах шаардлагагүй бөгөөд түүнд нь хариуцагч этгээдүүд сарын дотор хариу өгөх ёстой. Энэхүү хариу өгөх хугацааг дээд тал нь 3 хүртэлх сараар сунгах боломжтой юм. Мэдээллийг үйл ажиллагааны нууц байдал, олон улсын харилцаа, үндэсний болон иргэдийн аюулгүй байдал, шудрага ёс, шүүхийн өмнөх эрх тэгш байдал,арилжааны нууц, оюуны өмч, хувь хүнтэй холбоотой мэдээллийн нууц зэргийг илрүүлэх, хор уршиг тарих аюултай бол мөн гуравдагч этгээдээс сайн дураараа өгсөн мэдээлэл, байгаль орчинтой холбоотой хэт нарийвчилсан мэдээлэл байх юм бол өгөхөөс татгалзаж болно.

Мэдээлэл өгөхгүй байх нөхцлийг маш хатуу чанга байлгах мөн иргэд тухайн мэдээллийг нийтэд зарлах талаар хэр их хүсэж байгааг тухайн этгээд харгалзан үзэх ёстой. Мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг бичгээр өгөх бөгөөд яагаад татгалзав гэдгийг тодорхой дурьдсан байх шаардлагатай. Мэдээлэл гаргаж өгөх өртөг бодитой байх ёстой. Шүүхэд өргөдөл гаргах эрх эсвэл эцсийн шийдвэрийг гаргах бие даасан хуулийн этгээд байх ёстой.

Төрийн түшээд мэдээлэл авах журмыг гаргаж түүнийгээ олон нийтэд таниулан сурталчлах, (мөн электрон хэлбэрээр), шинжилгээ судалгааг хэвлэн нийтлэх, байгаль орчны нөхцөл байдлын талаар мэдэгдэл хийх, зайлшгүй аюул тохиолдож болзошгүй түүнийг нэн даруй иргэдэд мэдээлж байх үүрэгтэй.

Энэхүү Конвенцэд 44 орон гарын үсэг зурснаас 37 орон нь хүлээн зөвшөөрч хэрэгжүүлээд байна. Бүс нутагт МЭЧ хуулийг хэрэгжүүлж эхлэхэд энэхүү Конвенци гол үүргийг нь гүйцэтгэсэн юм. 36 орон үүгээр жишиг болгон нийтлэг хуулийг хүлээн зөвшөөрсөн юм. Мөн түүнчлэн, үүнийг Европын Холбоо бүх гишүүн орнуудын баритмлах Жишиг Хууль болгон баталжээ.

Европын Зөвлөл

46 орны хамтран баталсан хэлэлцээр дээр үндэслэн байгуулагдсан Европын Зөвлөл өөрийн гишүүн орнуудад мэдээллийг чөлөөтэй өгөх талаар удаан хугацааны турш санал болгож ирсэн билээ. 1979 онд Парламентуудын Ассемблей, Европын Сайд нарын Зөвлөлд өөрийн орнуудыг мэдээлэл өгөх хуулийг санаачлан хэрэгжүүлэхийг санал болгож байсан юм¹⁰. 1981 онд Сайд нарын Зөвлөл засгийн газрууд, унаган болон хууль зүйн эрх бүхий иргэдэд төрийн түшээдийн гарт байгаа мэдээллийг авах эрх олгох хууль санаачлан хэрэгжүүлэхийг санал болголоо¹¹.Зөвлөл 1983 онд

⁹ Мэдээлэл түгээх , Байгаль Орчинтой Холбоотой Асуудлаар Шүүхэд Хандах Боломж, Шийдвэр гаргах Явцад Оролцох Иргэдийн Оролцоог Нэмэгдүүлэх Конвенци. <http://www.unece.org/env/pp/treatytext.htm>

¹⁰ ПА-н санал 854 (1979).

¹¹ Төрийн мэдэлд байгаа мэдээлэл хүртэх эрхийн тухай Сайд нарын Зөвлөлөөс гишүүн орнуудад хандан гаргасан санал No. R (81)19

байгаль орчныг хамгаалах конвенци зохион байгуулж байгаль орчинтой холбоотой мэдээлэл авах эрхийн шаардлагын талаар хэлэцсэн¹².

2002 онд Сайд нарын Зөвлөл гишүүн орнууд МЭЧ хэрэгжүүлэх тухай саналыг баталлаа¹³. Төрийн байгууллагуудад байгаа албан ёсны баримт бичгүүдтэй хүн болгон танилцах эрхтэй гэсэн зарчмыг үндэслэл болгон засгийн газрууд мэдээллийн эрх чөлөөний талаар хэрхэн хууль боловсруулан хэрэгжүүлэх дэлгэрэнгүй зарчмыг энэхүү саналд оруулсан байна. Үүнд мэдээлэл авах журмууд, мэдээлэл өгөхгүй байх боломжит шалтгаан, шүүхэд давж заалдах журмуудыг энэхүү саналд оруулжээ. Одоогийн байдлаар энэхүү зарчмууд дээр тулгуурлан ажлын групп конвенци хийхээр ажиллаж байна. Хүний Эрхийн Европын Конвенцийн 10 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангаж өгсөн байдаг¹⁴. Өнөөг хүртэл Европын Хүний Эрхийн Шүүх энэхүү зүйлд заасны дагуу мэдээлэл авах ерөнхий эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар байгаа юм.¹⁵ Гэсэн хэдий ч 8 дугаар зүйлд заасны дагуу (хувийн нууц) иргэдийн сайн сайхан амьдралд саад учруулж болзошгүй тохиолдолд мэдээлэл авах хязгаарлагдмал эрхийг хүлээн зөвшөөрсөн юм¹⁶. Мөн түүнчлэн 8 дугаар зүйлд заасны дагуу тагнуулын байгууллага болон засгийн газар тухайн иргэний талаар ямар мэдээлэл цуглуулсан эсэх талаар мэдээлэл авах эрхийг хүлээн зөвшөөрсөн байна¹⁷.

Европын Холбоо

Гишүүн орнууд нь МЭЧ хуулийг хэрэгжүүлэх эсэх тал дээр Европын Холбооны зүгээс хүлээсэн ямар нэгэн үүрэг хариуцлага байдаггүй. Гэхдээ гишүүн орнууд байгаль орчин хамгаалал¹⁸, хэрэглэгчийг хамгаалах, засгийн газрын худалдан авалт, хамгийн сүүлд төрийн мэдээллийг дахин ашиглах¹⁹ хууль гэх мэт зүйлс дээр иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах тухай удирдамж чиглэлийг Европын Холбоо батлан гаргасан билээ. Одоогоор Европын Холбоо гишүүн орнуудаа нэлээн их хэмжээний мэдээллийг үнэгүйгээр түгээхийг шаардах шинэ удирдамж бий болгох тал дээр ажиллаж байна²⁰. 1990 оны байгаль орчинтой холбоотой мэдээлэл авах боломжийн талаархи удирдамжийн дагуу Европын Холбооны ихэнх орнууд өөрсдийн хуулиудаа батлан гаргасан билээ. Одоо зөвхөн Люксембург, Кипр Мальт улсууд нэгдсэн хуульгүй байгаа бөгөөд Итали, Грек, Испани улсуудын хууль олон улсын жишигт харьцуулах юм бол сулавтар хэмээн тооцогддог. Дээр нь Европын Холбооны хэлэлцээрүүд нь хуулийн этгээдүүдийг мэдээллийн эрх чөлөөний дүрмийг даган баримтлахыг шаардахаас гадна иргэдийг Европын Холбооны улсуудын аль ч хуулийн этгээдээс мэдээлэл шаардах эрхээр хангахыг шаарддаг. Европын Холбооны Гэрээний 255 дугаар зүйлд зааснаар:

¹² Байгаль орчинд хөнөөлтэй үйл ажиллагаа явуулсны төлөө хүлээлгэх иргэний хариуцлагын тухай Конвенци 1993 он 6 сар 21

¹³ Албан ёсны бичиг баримтыг нийтэд хүртээлтэй болгох тухай Сайд нарын Зөвлөлийн гаргасан удирдамж Rec(2002)2

¹⁴ Хүний эрх болон Үндсэн эрх чөлөөний тухай Конвенци, ETS-005.

<http://conventions.coe.int/Treaty/en/Treaties/Html/005.htm>

¹⁵ Сорбу нарын хүмүүс Молдавын эсрэг, хэргийг үз (Applications nos. 73562/01, 73565/01, 73712/01, 73744/01, 73972/01); Иргэн Лийндэр Шведийн эсрэг, хэрэг 1987 он 3 сар 26, дугаар А no. 116.

¹⁶ Гуерра нарын хүмүүс Италийн эсрэг, хэрэг 116/1996/735/932

¹⁷ Иргэн Ротару Румыны эсрэг, хэрэг - 28341/95 [2000] ECHR 192 (2000-05-04); Зигерштэд-Виберг нарын хүмүүс Шведийн эсрэг, хэрэг (application no.

62332/00); Иргэн Турек Turek v. Slovakia - 57986/00 [2006] ECHR 138 (14 February 2006).

¹⁸ Байгаль орчны мэдээллийг нийтэд хүргэх тухай Европын Парламент, Зөвлөлийн хамтарсан удирдамж 2003/4/ЕС 2003-01-28 болон Зөвлөлийн 90/313/ЕЕС удирдамжийг хүчингүй болгосон тушаал (OJ L 41 of 14.02.2003, p. 26).

¹⁹ Төрийн мэдээллийг дахин ашиглах тухай Европын Парламент болон Зөвлөлийн удирдамж 2003/98/ЕС. http://europa.eu.int/information_society/policy/psi/docs/pdfs/directive/psi_directive_en.pdf

²⁰ Европ дахь Спашиал (өргөн хэмжээний) мэдээллийн Дэд бүтэц <http://inspire.jrc.it/>

1. Холбооны иргэн хүн, мөн гишүүн орны албан ёсны холбогдох байгууллагад бүртгүүлсэн, байнгын оршин суугч, унаган болон хууль зүйн эрх бүхий иргэн Европын Парламент, Зөвлөл, Хорооны баримт бичгүүдтэй танилцах эрхийг тус гэрээний 2 ба 3 бүлэгт заасны дагуу хангах болно.
2. Төрийн болон хувийн ашиг сонирхол дээр үндэслэн энэхүү мэдээллийн эрхтэй холбоотой хязгаарлалт, журмуудыг Зөвлөл тодорхойлоно. Ингэхдээ Амстердамын Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 2 жилийн дотор, энэхүү гэрээний 251 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлох болно.
3. Дээр дурьдсан нэр бүхий байгууллагууд нь өөрийн бичиг баримттай харьцах дотоод дүрэм журамтай уялдуулан өөрийн бичиг баримттай бусдыг танилцуулна²¹.

Европын Холбооны хуулийн этгээд бүр улс үндэстэнгүүдийн мэдээллийн эрх чөлөөний дүрэмтэй ижил төстэй дүрмийг хэрэгжүүлж эхэлсэн²².

Европын Омбудсман (хөндлөнгийн хянагч) энэ бүх үйл ажиллагааг ерөнхийд нь хянах бөгөөд Европын Шудрага Ёсны Шүүхэд ч мөн өргөдлөө гаргаж болно²³.

Африкийн Холбоо

2003 оны 6 сард Авилгалтай тэмцэх, түүнээс Урьдчилан сэргийлэх Африкийн Холбооны Конвенци батлагджээ²⁴. “Мэдээллийн хүртээмж” гэсэн 9-р зүйлд:

Авилгал эсвэл түүнтэй адилтгах хэргийн эсрэг тэмцэхэд тус болох мэдээллийг авах эрхийг хангах хууль эрх зүйн орчинг Улс болгон бүрдүүлэх.

Энэхүү гэрээг Африкийн Холбооны 53 орны 40 нь нэгдэж, 15 нь хэрэгжүүлж эхэлжээ. Энэ гэрээ 2006 оны 7 сараас эхлэн хүчин төгөлдөр боллоо.

Хүн болон Иргэдийн Эрхийн Африкийн Хартийн 9 дүгээр зүйлд “Хувь хүн бүр мэдээлэл хүлээн авах эрхтэй”²⁵ гэж заасан байдаг. Энэхүү Конвенциор Африкийн Хүний Эрхийн Хороо байгуулагджээ. 2002 оны 10 сарын 22ний өдөр Африк дахь Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Тунхаглалыг Африкийн Хүний Эрхийн Хороо баталлаа²⁶. Энэхүү Тунхаглал нь гишүүн орнуудыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрөхийг уриалжээ. “Мэдээллийн Эрх Чөлөөний” 4 дүгээр хэсэгт:

1. Төрийн байгууллагууд нь мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашиг, сайн сайхны төлөө хадгалах бөгөөд энэхүү мэдээллийг хүн бүр авах эрхийг хуулинд заасны дагуу хангасан болно.

2. Дараахи зарчмуудыг үндэслэн мэдээлэл авах эрхийг баталгаажуулна:

Төрийн байгууллагуудад байгаа мэдээллийг хүн бүр авах эрхтэй; ямар нэгэн эрхийг хамгаалах шаардлагатай бол хувийн байгууллагуудад байгаа мэдээллийг хүн бүр авах эрхтэй; мэдээлэл өгөхөөс татгалзсан тохиолдолд бие даасан этгээд эсвэл шүүхэд өргөдөл

²¹ Европын Холбоог байгуулах тухай гэрээний товч, Official Journal C 325, 2002 оны 12 сарын 24 <http://europa.eu.int/eur-lex/lex/en/treaties/dat/12002E/htm/12002E.html>

²² ЕП, Зөвлөл, Хорооны баримт бичгийг нийгэд хүргэх тухай Европын Парламент болон Зөвлөлийн гаргасан журам (ЕС) No 1049/2001, 2001 5 сарын 30

Official Journal L145, 2001 он 5 сар 31, хуудас 43

²³ <http://www.ombudsman.europa.eu/home/en/default.htm>

²⁴ Авилгалтай тэмцэх, түүнээс Урьдчилан сэргийлэх Африкийн Холбооны Конвенци, Мозамбик, Мапуто хот, 2003-07-11 [http://www.africa-](http://www.africa-union.org/root/au/Documents/Treaties/Text/Convention%20on%20Combating%20Corruption.pdf)

[union.org/root/au/Documents/Treaties/Text/Convention%20on%20Combating%20Corruption.pdf](http://www.africa-union.org/root/au/Documents/Treaties/Text/Convention%20on%20Combating%20Corruption.pdf)

²⁵ Хүн болон Иргэдийн Эрхийн Африкийн Харти, Кени, Найроби 1981 оны 6 сар. <http://www.africaunion.org/root/au/Documents/Treaties/Text/Banjul%20Charter.pdf>

²⁶ Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх Тунхаглал, Хүн болон Иргэдийн Эрхийн Хороо, 32 дахь Хурал, 2002-10 сарын 17 – 23 өдөр

гаргах эрхтэй; нийтийн эрх ашигтай холбоотой мэдээллийг төрийн байгууллага уг мэдээллийг авах хүсэлт гаргаагүй байсан ч нийтэд танилцуулах ёстой; бусдын эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулаж болзошгүй тохиолдол, ардчилсан нийгмийн зарчмаас гажсан үйлдлийг нийтийн тусын тулд нийтэд илчилсэн хэн нэгнийг ямар нэгэн хэлбэрээр шийтгэх, хариуцлага оногдуулах ёсгүй; нууцын тухай хуулийг МЭЧ ийн зарчим дээр үндэслэн боловсруулах.

3. Төрийн эсвэл хувийн мэдэлд байгаа хувь хүнтэй холбоотой мэдээллийг иргэд өөрсдөө шинэчлэн өөрчлөх, танилцах, эсвэл засан залруулах эрхтэй²⁷.

SADC (Өмнөд Африкийн Хөгжлийн Хороо)-ны Авилгалын Эсрэг Протокол

ӨАХХ нь Африкийн 14 орныг өөрийн гишүүн болгосон Хороо юм²⁸. 2001 онд энэхүү Хороо Авилгалын Эсрэг Протоколыг баталжээ²⁹. Урьдчилан сэргийлэх тухай 4 дүгээр зүйлд:

1. Авилгал бий болох нөхцөл, авилгалыг устгахын тулд мэдээлэл авах эрхээр иргэдийг хангах, тэрхүү эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ, эрх зүйн орчин бүрдүүлэхийг Гишүүн орон бүр энэхүү Протоколын 2 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

Протоколд 14 гишүүн орон бүгд гарын үсэг зурсан бөгөөд үүнээс 8 орон нь хуульчилсан байна³⁰. Энэхүү Протокол хүчин төгөлдөр болоход дахин 1 орон нэгдэн орох шаардлагатай байгаа.

Америкийн Улсуудын Байгууллага

Мэдээллийн Эрх Чөлөөний үнэ цэнийг Америкийн Улсуудын Байгууллага удаа дараалан өндрөөр үнэлэж байсан юм. 2003³¹ болон 2004³² онуудад АУБ-ын Ерөнхий Хороо гишүүн орнуудаа МЭЧ-ийн хуулийг даган мөрдөхийг уриалж байлаа.

Хүний Эрхийн Америкийн Конвенцийн 13 дугаар зүйлд:

1. Хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх, бодох эрхтэй. Энэхүү эрх нь аман, бичгэн, хэвлэмэл, урлагийн хэлбэрээр эсвэл хэн нэгний өөрийн сонгосон хэлбэрээр мэдээлэл эсвэл үзэл бодлыг эрэлхийлэх, хүлээн авах, тараах зэргийг хамруулна.

Америк Дундын Хүний Эрхийн Хороо Чили улсыг 13 дугаар зүйл буюу байгаль орчинтой холбоотой мэдээллийг гаргаж өгөөгүй гэдэг үндэслэлээр буруутгажээ³³. Өнөөгийн байдлаар энэ хэргийг Америк Дундын Хүний Эрхийн Шүүх шалгаж байна.

2000 оны 10 дугаар сард энэ Хороо Мэдээллийн Эрх Чөлөөний Зарчмын Тунхаглалыг батлан зарлажээ. 4 дүгээр Журамд мэдээлэл авах эрхийг:

4. Улсын мэдэлд байгаа мэдээллийг авах эрх нь хүн бүрийн үндсэн эрх юм. Энэхүү эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх үүргийг Улс бүрэн хариуцна. Энэхүү хуульд хамаарагдахгүй байх нөхцөл, тохиолдлыг урьдчилан хуульчилсан байх ёстой бөгөөд ардчилсан нийгэм дэх үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үед л энэ хуулийг даган мөрдөхгүй байж болно³⁴.

²⁷ Хүн болон Иргэдийн Эрхийн Хорооны 32 дахь Хуралаар батлагдсан 2002-10 сарын 17 – 23, Гамби, Банжул хот

²⁸ ӨАХХ-ийн түүх, хөгжил өнөөгийн байдал –ыг үз <http://www.sadc.int/english/about/history/index.php>

²⁹ Авилгалын Эсрэг Протокол. http://www.iss.co.za/AF/RegOrg/unity_to_union/pdfs/sadc/protcorrupt.pdf

³⁰ ӨАХХ-ын Протокол бусад хуулийн хэрэгслийн талаархи гишүүн орнуудын гарын үсэг зурсан болон хэрэгжүүлж эхэлсэн байдал. (2006 оны 3 сар) <http://www.sadc.int/english/documents/legal/protocols/status.php>

³¹ AG/RES. 1932 (XXXIII-O/03)

³² AG/RES. 2057 (XXXIV-O/04)

³³ АДХЭХороо, АДХЭШүүх Чили улсын эсрэг, хэрэг 12.108 Claude Reyes et al, 2005 он 7 сар 8. http://www.justiceinitiative.org/db/resource2/fs/?file_id=16278

³⁴ Мэдээллийн Эрх Чөлөөний Зарчмын Тунхаглал. <http://www.cidh.oas.org/Basicos/principles.htm>

Мөн түүнчлэн хувь хүмүүс өөрсөдтэйгээ холбоотой төрийн болон хувийн байгуулагууд дахь мэдээллийг авах эрхтэй гэж 3 дугаар журамд заасан байдаг.

Чапултепекийн Тунхаглал

Энэхүү Тунхаглал 1994 оны 3 сард Мехико хотод болсон Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай Бүс Нутгийн Хуралдааны үеэр батлагдан гарсан юм³⁵. Тунхаглал үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь ардчилсан нийгмийг тэтгэх гол хүчин зүйлийн нэг болохыг хүлээн зөвшөөрөхийг уриалжээ.

3. Төрийн хүрээнд бий болсон мэдээллийг цаг хугацаанд нь зохистойгоор хүргэх үүргийг төрийн түшээдэд хуулиар хүлээлгэнэ.

Энэхүү Тунхаглалд 3 бүсийн 29 орны удирдагч гарын үсэг зуржээ. Эдгээр улсуудаас 12 орон нь МЭЧ ийн хуулийг хэрэгжүүлж эхэлжээ.

Арабн Хүний Эрхийн Харти

2004 оын 5 сард Тунист болсон Арабын Холбооны Улсуудын Дээд Хэмжээний уулзалтын үеэр энэхүү Харти батлагдсан байна³⁶. Энэ нь 1994 онд батлагдсан боловч аль ч гишүүн орон хэрэгжүүлээгүйн улмаас хүчин төгөлдөр болоогүй Хартийн оронд шинээр гарч ирсэн Харти юм.

Энэ шинэ Харти нь НҮБ-ийн Хүний Эрхийн Хороо болон бусад ажиглагч нарын сайшаалыг хүртсэн, хуучин 1994 оны Хартиг бодвол үлэмж сайжирсан байлаа. Энэ Харти НҮБ-ын Хүний Эрхийн Тунхаглалын үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрөхөөс гадна өөрийн гэсэн илүү тодорхойлолтуудыг бас оруулсан байна. 32 дугаар хэсэгт:

(а) Энэхүү Харти нь мэдээлэл авах эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, мэдээллийн аль ч суваг, хэлбэрээр мэдээллийг эрэлхийлэх, хүлээн авах, түгээх эрхийг олгох болно.

б) Энэ төрлийн эрх, эрх чөлөө нь тухайн орны ёс заншилтай уялдах ёстой бөгөөд бусдын нэр хүнд, эрх чөлөөг хөндөх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, олон нийтийн эрүүл мэнд, ухамсарт хохирол учруулж болзошгүй бол хязгаарлалт тавигдах болно.

Энэ Хартийг нэлээн хэдэн орон хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан боловч бүрэн хэрэгжиж хүчин төгөлдөр болоход наад зах нь 7 орон энэ Хартад нэгдэн орох шаардлагатай байгаа юм.

Хамтын Нөхөрлөлийн Орнууд

Энэ нь Британийн Эзэнт Гүрэнд багтаж байсан 53 орны холбоо юм. 1980 онд Хамтын Нөхөрлөлийн Орнууд, өөрийн гишүүн орнуудыг иргэддээ мэдээлэл авах боломжийг нь нээж өгөхийг уриалжээ. 1999 онд Хамтын Нөхөрлөлийн Орнуудын Хуулийн Сайд нар, мэдээллийг дэлгэх, ил тод байдлыг түгээх, хязгаарлагдмал нууцлалтай, бүртгэлийн удирдлага, мэдээллийг хянах эрхийг зарчим болгосон МЭЧ хуулийг даган мөрдөхийг өөрийн гишүүн орнуудад санал болгов³⁷.

³⁵ Чапултепекийн Тунхаглал, 1994.

http://www.declaraciondechapultepec.org/english/declaration_chapultepec.htm

³⁶ Мерват Ришмави, Арабын Хүний Эрхийн Харти, 361-376, 2005

³⁷ Тринидад Табога, Испани ХНО-ын Хуулийн Сайд нарын уулзалтаас гаргасан санамж бичиг, 1999 оны 5 сар

2003 онд ХНО-ын Нарийн Бичгийн Дарга нарын Газраас МЭЧ-ний тухай жишиг хуулийг гаргажээ³⁸. Энэхүү жишиг нь парламентийн системтэй Канад, Австрали болон бусад ХНО-ын МЭЧ-ийн хуулин дээо үндэслэгдсэн байлаа.

Өнөөгийн байдлаар ХНО-ын 12 орон МЭЧ-ний тухай хуулийг даган мөрдөж, 20 гаруй орон хэрэгжүүлэх шатандаа явж байна.

Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл

Энэ хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд багтдаг байсан 12 улсын холбоо юм³⁹. Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн Парламентын Холбоо мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хамгаалалт, улсын нууц, байгаль орчинтой холбоотой мэдээллийг авах тухай жишиг хууль боловсруулсан байна⁴⁰.

Азийн Хөгжлийн Банк, Ази-Номхон далайн бүс нутаг дахь Авилгалын Эсрэг санаачлага

Азийн Хөгжлийн Банк болон Эдийн Засгийн Хамтын Нөхөрлөл Хөгжлийн Байгууллага (OECD) Ази-Номхон далайн бүс нутаг дахь Авилгалын Эсрэг санаачлагыг үүсгэсэн бүс нутгийн олон орны дэмжлэгийг хүлээжээ. Санаачлагын үр дүнд гарсан Ази-Номхон далайн бүс нутгийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө-г “: улс хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ энэхүү санаачлагад нэгдсэнээр уг санаачлагыг заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй юм⁴¹. Энд хэд хэдэн зарчим дээр ил тод, нээлттэй байдлыг сайжруулахын тулд тусгайлсан заалт оруулж өгсөн байна. Үүнд: Төр засаг, олон нийт шаардлагатай мэдээлэл олж авахад нь шаардагдах арга зам, хэрэгслүүдийг санаачлан хэрэгжүүлэх”, засгийн газрын худалдан авалтыг нээлттэй болгох, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгох, аудитын үйл ажиллагаа, авилгалын эсрэг үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх, төрийн албан хаагчдын эд хөрөнгө, өр зээлийг ил тод болгох гэсэн заалтууд оржээ.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨХ УЛС ОРНУУДЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТ

Авилгалын эсрэг тэмцэх, сайн засаглалыг төлөвшүүлэх, мөн хүний эрхийг хангахад Мэдээллийн Эрх Чөлөө тун чухал үүрэгтэй болохыг улс орнууд улам ихээр ойлгож, хүлээн зөвшөөрөх боллоо. 80 гаруй орон мэдээлэл авах эрхийг өөрийн үндсэн хуулиндаа тусгасан байна. 70 орчим орон мэдээллийн эрх чөлөөний тухай үндэсний хууль гаргасан байдаг бөгөөд одоогоор 50 гаруй орон мэдээллийн эрх чөлөөний тухай хууль гаргах шатандаа явж байна.

Мэдээлэл Авах Үндсэн Хуулиар Баталгаажсан Эрх

Мэдээлэл авах эрхийг Үндсэн хуулиндаа дээдлэн оруулах нь сүүлийн үед нэлээн түгээмэл үзэгдэл болж байна. Иргэдээ мэдээлэл авах эрхийг нь үндсэн хуулиараа баталгаажуулж өгсөн 80 гаруй орон байна. Ялангуяа сүүлийн 10 гаруй жилийн дотор энэ эрхийг үндсэн хуулиндаа оруулсан орны

³⁸ ХНО –ын Нарийн Бичгийн Дарга нарын Газар Мэдээллийн Эрх Чөлөөний Жишиг Хууль, 2003 оны 5 сар http://www.cpaq.org/CommonwealthFOIAAct_pdf_media_public.aspx

³⁹ Веб хуудас <http://www.cis.minsk.by/main.aspx?uid=74>

⁴⁰ Парламентийн Холбооны жишиг хуулиудын жагсаалт: <http://www.iacis.ru/html/index-eng.php?id=54&nid=9>

⁴¹ ‘Ази-Номхон далайн бүс нутгийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөө’ <http://www1.oecd.org/daf/asiacom/ActionPlan.htm#actionplan>

тоо огцом өссөн юм. Латин Америк, Зүүн болон Төв Европын шилжилтийн үедээ явж байгаа олон орон өөрсдийн шинэ Үндсэн хуулиндаа мэдээлэл авах эрхийг тусгаж өгсөн байдаг. Мөн хуучин Үндсэн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулан мэдээлэл авах эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан Финланд, Норвег гэх мэт улсууд бас байна.

Ерөнхийдөө энэ эрх нь ямар ч иргэн эсвэл хүн засгийн газраас мэдээлэл шаардах эрхийг олгодог юм. Өмнөд Африкийн Үндсэн хууль дэлхий дээрхи хамгийн өргөн хүрээг хамарсан эрхийг иргэддээ олгодог. Иргэд эрхээ эдлэх эсвэл ямар нэгэн эрхээ хамгаалахын тулд хувь хүнээс мэдээлэл шаардах эрхтэй байдаг. Харин зарим нь их хязгаарлагдмал шинжтэй байх нь бий. Хабейасын Мэдээллийн тухай заалт Латин Америкийн орнуудын иргэдэд зөвхөн өөрийн хувийн мэдээлэлтэйгээ танилцах эрхийг л олгодог. Төв Азийн зарим улсуудад мэдээлэл авах эрхийг “өөрсдийн эрх, ашиг сонирхолын үүднээс” гэсэн үүднээс тайлбарладаг.

Япон, Энэтхэг, Солонгос, Пакистан, Израйль, Франц гэх зэрэг улсын дээд шүүх хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийг Үндсэн хуулиндаа тусгасан нь мэдээлэл авах эрхийг хангасан байна гэж тайлбарлах нь тохиолддог.

Мэдээлэл авах эрхийг үндсэн хуулинд оруулснаар энэ эрх хүчин төгөлдөр болж хэрэгжих үү үгүй юу гэдэг дээр их санал зөрөлдөөн гардаг. 1987 онд Филиппиний Дээд Шүүх Үндсэн хуулинд оруулсан мэдээлэл авах эрхийг хуулийн нэмэлт заалт оуулалгүйгээр шууд хэрэгжүүлэх боломжтой гэсэн дүгнэлт гаргажээ⁴². Угандад мөн адил дотоодын/үндэсний хууль гаргахаас өмнө хэрэгжүүлж байв. Өмнөд Африкт Үндсэн хууль нь засгийн газрыгүндэсний МЭЧ-ний тухай тусгайлсан хууль гарган хэрэгжүүлэхийг шаарддаг ажээ. Болгарт, Үндсэн Хуулийн Цэц 1996 онд гаргасан шийдвэртээ Үндсэн хуулинд мэдээлэл авах эрхийг тусгаж өгсөн боловч үүнийг хэрэгжүүлэхийн тулд энэ эрхийг хуулиар зохицуулах хэрэгтэй гэж заасан байдаг. Үндсэн хуулиндаа мэдээлэл авах эрхийг тусгасан орнуудын бараг тал нь нэмэлт мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар энэ эрхийг хангаж байдаг.

Зарим МЭЧ-ний хууль нь Үндсэн хуультайгаа адилтгах нөлөөтэй байдаг. Шведэд, Хэвлэлийн Эрх Чөлөөний Акт нь Шведийн Үндсэн хуулийг бүрдүүлдэг 4 Үндсэн хуулийн нэг болдог. Энэ хуулинд хийх аливаа өөрчлөлт нь 2 шатлал бүхий Парламентаар дамжин маш удаан хугацаанд хийгддэг юм. Зарим орнууд, МЭЧ-ний хуулиа бусад хуулиасаа дээгүүр авч үздэг бөгөөд Канадад энэ хуулийг “бараг л үндсэн хууль” гэж тооцдог. Шинэ Зеландын Дээд Шүүх 1988 онд энэ хууль [Албан Ёсны Мэдээлэл] өөрийн зайлшгүй байх шаардлага, үр нөлөөгөөрөө Үндсэн хуультай адилтгах чанартай юм гэж тодорхойлсон байдаг⁴³.

МЭЧ-ний Хууль Батлахад Нөлөөлдөг Хүчин Зүйлүүд

Аливаа засгийн газрыг МЭЧ-ний хуулийн хэрэгжүүлэхэд хүргэдэг дотоод, гадаадын олон тооны хүчин зүйлс байдаг. Ихэнх орнуудад авилгалын эсрэг тэмцэгч бүлгүүд, хэвлэл мэдээлэл, байгаль орчныг хамгаалах бүлгүүд гэх мэт иргэний нийгмийн бүлгүүд энэхүү хуулийг санаачлах, хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн байдаг. Мөн түүнчлэн цаг үетэйгээ хөл нийлүүлэх шаардлагатай байгааг засгийн газрууд ойлгож эхэлжээ.

Авилгал ба шуугиан Ил тод нээлттэй байдал байхгүй байснаас болж үүссэн хямралын дараа МЭЧ-ний хуулийг хэрэгжүүлэх тохиолдол их гардаг. Шинэ нийгэм соёлыг бүтээн байгуулж, шилжилтийн үедээ байгаа орнуудын Авилгалын эсрэг компани ажиллагаа маш өндөр үр дүнд хүрсэн. Олон зууны ардчиллын туршлагатай Ирланд, Англи, Япон зэрэг орнуудад иргэний нийгмийн хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа, байгаль орчин, эрүүл

⁴² Иргэн Легаспи Иргэний Үйлчилгээний Хорооны эсрэг, хэрэг, 150 SCRA 530, 1987 оны 5 сарын 29

⁴³ Цагдаагийн Комиссар Омбадсманы эсрэг, хэрэг [1988] 1 NZLR 385

мэндтэй холбоотой улс төрийн шуугиан тарьсан асуудлууд гарсны дараа л эдгээр улс МЭЧ-ний хуулийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж эхэлжээ. ТУХНОрнууд Чернобылийн гамшгаас үүдэн МЭЧ-ний хуулийг даган мөрдөх болжээ.

Олон Улсын Шахалт . Мэдээлэл авах эрхийг бий болгоход олон улсын зүгээс ихээхэн нөлөө үзүүлдэг. Хамтын Нөхөрлөлийн Орнууд, Европын Зөвлөл, Америкийн Улсуудын Холбоо гэх мэт олон улсын байгууллагууд мэдээлэл авах эрхтэй холбоотой хууль боловсруулах удирдамж, жишиг хуулиудыг гаргасан байдаг. Европын Зөвлөл 2003 оны 9 сард дэлхийн анхны мэдээлэл авах хэлэлцээрийг боловсруулах шийдвэр гаргажээ.

Дэлхийн Банк, Олон Улсын Валютин Сан болон бусад байгууллагууд санхүүгийн системээ илүү хариуцлагатай нарийн болгох, авилгалыг бууруулахын тулд МЭЧ-ний хуулийг даган мөрдөхийг шахдаг билээ⁴⁴. Аархуусын Конвенци хэдэн арван орныг иргэд байгаль орчинтой холбоотой мэдээлэл авах нөхцлийг нь бүрдүүлж өгөх боломжийг нь бүрдүүлжээ. Боснийг удирдаж байгаа олон улсын байгууллагууд энэ хуулийг санаачлах шийдвэр гаргажээ.

Орчин үе болон Мэдээллийн эрин. Интернэтийн өргөн тархалт, хөгжил нь олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн мэдээллийн хэрэглээг улам их болголоо. Засгийн газрын дотоод үйл ажиллагаа, бүртгэлийн системийг сайжруулах, электрон засаглалыг хөгжүүлэх шаардлага нь мэдээллийг өргөн тараах засгийн газрын зорилго болон хувирчээ. Словенд Мэдээллийн Яам нь МЭЧ-ний хуулийг санаачлан хэрэгжүүлэхэд голлох дуу хоолой нь болж байлаа.

МЭЧ-ний Хуулийн Түүх

Мэдээлэл авах эрх, түүгээрээ дамжуулан төртэй хариуцлага тооцох явдал шинэлэг зүйл биш юм. Энэ ойлголт анх 18 дугаар зууны үед сэргэн мандалтын үеэр бий болсон юм. 1766 онд батлагдсан Шведийн Хэвлэлийн Эрх Чөлөөний Акт нь төрийн мэдээлэл нь нийтэд нээлттэй байх ёстой, тэрхүү мэдээллийг иргэд авах, шаардах эрхтэй гэсэн үндсэн зарчмын ойлголтыг бий болгож өгсөн юм. 1789 оны Францын Хүний Эрхийн Тунхаглалд төсвийн зарцуулалт иргэдэд нээлттэй байх замыг нээж өглөө: “Бүх иргэд өөрийн биеэр эсвэл төлөөлөгчөөр дамжуулан нийтийн тусын төлөө, ямар ч саадгүйгээр , төсвийг юунд зарцуулав гэдгийг мэдэх эрхтэй” гэжээ. 1795 онд Нидерландад батлагдсан ижил төстэй тунхаглалд “хүн бүр төрийн албан хаагчаас түүний хийсэн үйлдэл, шийдвэр нь зөвтгөх шалтгаантай эсэх талаар асуун шалгаах эрхтэй” хэмээн заасан байдаг. АНУ-ыг үндэслэгч нар албан хаагч мэдээллийг бусдад хүргэлгүй хянах нь ямар их эрх мэдэл агуулж болохыг хүлээн зөвшөөрч байлаа. Америкын Эрх Чөлөөний Тунхаглалд, Британы нээлттэй засаглалыг хаан боогдуулсан дүрэм журам нь ардчиллыг бий болгоход саад учруулж байгаа тухай дурьджээ. Патрик Хенри Үндсэн Хуулийн Конгрессийн нууцлаг байдлыг шүүмжлэн “Хүмүүсийн эрх чөлөө, тэднийг удирдаж байгаа хүмүүсийн үйл ажиллагаа нууц байсан тохиолдолд хэзээ ч батгалгаажиж байгаагүй, баталгаажихгүй ч байх болно” гэж хэлж байлаа.

Бараг 100 гаруй жилийн турш Швед (Финланд зарим нэг талаараа) мөн сонирхолтой нь Колумб улсууд л энэ эрхийг хууль ёсоор рүлээн зөвшөөрсөн улсууд байлаа. Дэлхийн 2 дугаар дайн дуусаж Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдан хүний эрхийн талаар хүчтэй яриа гарч ирэх үед л мэдээлэл авах эрхийн тухай дурьдах болж улмаар улс орнууд засгийн газрын мэдээллийг нийтэд түгээх, нээлттэй болгох алхмуудыг хийж эхэлжээ. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 19 дүгээр зүйлд хүн бүрийг мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй болгохыг уриалсан байдаг. Тун удалгүй Скандинавын хойгийн орнууд Шведийн загварыг сонирхож эхэллээ. Финланд 1951 онд,

⁴⁴ Тоби Макинтош, Хөгжлийн зорилгод МЭЧ-ний хуулиудыг хамруулах нь, 2006 оны 3 сарын 22. <http://www.freedominfo.org/features/20060322.htm>

Норвег, Дани 1970 онд өөрсдийн МЭЧ-ний тухай хуулиудыг баталжээ. Үүнээс хойшхи 30 жилийн хугацаанд 1966 онд АНУ, 1978 онд Франц, Нидерланд, Австрали, Шинэ Зеланд 1982 онд 1983 онд Канад улс энэ хуулийг баталлаа. Энэ нь засгийн газрын зарим нэг тусламжтайгаар явуулж байсан хэвлэл мэдээллийнхэн тэргүүлсэн хэдэн арван жилийн үйл ажиллагааны үр дүн юм.

Бүс Нутгийн Чиг Хандлага

МЭЧ-ний хуулийг даган мөрдөх явдал сүүлийн үед маш их эрчимжсэн. Сүүлийн 10 жилийн туршид батлагдсан хуулиудыг далайн давалгаатай зүйрлэсэн ч болохоор их байлаа. Анхлан бөмбөрцөгийн хойд талын хөгжингүй орнууд энхүү хуулийг батлаж байсан боловч аажимдаа дэлхий дахиныг хамран бүх тив дээр хэрэгжих болсон юм. Европын бараг бүх улсууд энэ хуулийг даган мөрдөж байгаа билээ. 1970-аад оноос эхлэн Баруун Европын орнууд энэ хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. Харин энэ нь Зүүн Европын орнуудад илүү хүчтэй өөрчлөлт авчирсан юм. Берлиний хана нуруулт, ЗХУ-ын задрал нь тухайн бүс нутагт энхүү хуулийг мөрдөж эхлэх суурийг тавьж анх Украин, Унгар улсууд 1992 онд, Азарбайжан 2005 үнд, Македон улс 2006 оны 1 дүгээр сард энэ хуулийг баталлаа. Том улсуудаас зөвхөн Орос, Беларусь, мөн зарим нэг жижиг улсууд энэ хуулийг хүлээн зөвшөөрөөгүй байна. Хэдийгээр Итали, Грек, Испани зэрэг улсууд ийм хуультай боловч түүнийгээ бүрэн хэрэгжүүлдэг хэмээн тооцогдоггүй.

Жорж Соросын 'Нээлттэй Нийгмийн Хүрээлэн'-г энд дурьдахгүйгээр өнгөрч болохгүй. Хүйтэн дайны дараах шилжилтийн үед энэхүү сангаар санхүүжүүлэгдсэн олон улсын болон орон нутгийн байгууллагууд Төв болон Зүүн Европын орнуудад ардчилалыг хөгжүүлэх арга замын нэг болгон нээлттэй нийгэм байгуулах үйл ажиллагааг тэргүүлсэн юм. Европын Хамтын Ажиллагаа Аюулгүй Байдлын Байгууллага, Европын Зөвлөл энд мөн адил үүрэг гүйцэтгэсэн билээ.

МЭЧ-ний талаар Америк тив ч анхаарал тавьж ирсэн юм. Мексик улс алива нэгэн мэдээлэл авах гэсэн хүсэлтийг анх гаргасан цагаас нь эхлэн дуусан дуустал нь хянаж, хүсэлтийг цаг тухайд нь биелүүлж байгаа эсэхийг шалгадаг бүртгэлийн систем бүхий дэлхийн хамгийн хүчтэй хуулиудын нэгийг баталсан юм. АНУ, Канад үеэ өнгөрөөсөн, шинэчлэх шаардлагатай, бүс нутгийн хамгийн сул хуулиудтай орнууд юм. Мэдээлэл авах эрхийн тухай хуулийг анх Колумб улс 1885 үнд баталж байсан бөгөөд түүний 1985 онд шинэчилсэн хувилбар барагтай бол хэрэглэгдэхгүй байна. Ямайка, Тринидад Тобаго, Белиз, Панам, Перу, Эквадор, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Антигуа Барбуда улсууд энэ хуулийг батлан хэрэгжүүлж байгаа билээ. Мэдээллийн хязгаарлагдмал эрх бүхий тогтоолуудыг Аргентин, Болив, Гватемал улсууд гаргасан. Үлдсэн орнууд бараг бүгд л энэ хуулийг батлах, хэлэлцүүлэх шатандаа байгаа юм. Эдгээр орнуудад Дэлхийн Банк болон бусад зээлдэгч байгууллагуудаас авилгалын эсрэг тэмцэлд хэрэгтэй хэмээн МЭЧ-ний хуулийг батлан, хэрэгжүүлэхийг шахаж байгаа юм. Америкийн Улсуудын Холбоо энэ ажилд толгойлон оролцож, 200 болон 2003 онд уриалга гаргаж, 2000 онд МЭЧ-ний хуулийн төслийг санаачлан гаргаж байлаа. Харин Ази-Номхон далайн бүс нутагт энэ хуулийг их л хязгаарлагдмал байдлаар хүлээн авч байна. Австрали, Шинэ Зеланд улсууд энэ хуулийг анхлан хэрэгжүүлж байсан боловч Австралийн Холбооны МЭЧ Акт дараа дараачийн засгийн газруудын үйл ажиллагаанаас болон суларч үл тоомсорлох байдалд оржээ. Өмнөд Солонгос, Тайланд энэ хуулийг 1990-д оны үед хэрэгжүүлж эхэлсэн боловч сүүлийн үед нүдэнд харагдахаар үр дүн гараагүй л байна. Япон улс энэ хуулийг 2000 онд баталсан бөгөөд орон нутгийн 3000 орчим нэгж өөрсдийн хуультай байна. Энэтхэгт мужууд эхлэн МЭЧ-ний хуулийг хэрэгжүүлж эхлэн авилгалд идэгдсэн орон нутгийн засаг захиргааны эсрэг тэмцсэн олон нийтийн байгууллагуудын гайхамшигтай амжилтуудын дараа 2002 онд энэ хуулийг засгийн газраас баталсан боловч хэрэгжүүлж эхлээгүй юм. Харин 2005 онд гарсан шинэ хууль илүү хүчтэй, бие даасан Мэдээллийн Хороог хүртэл байгуулсан байна. Хууль хэрэгжүүлж эхэлснээс хойш сайн, муу янз бүрийн үр дүн гарч байгаа боловч ирээдүйд их итгэл

төрүүлж байгаа юм. Пакистаны гаргасан журам нь хязгаарлагдмал үр дүн авчирсан. Хятадад хүртэл Гуанжоу, Шанхайд авилгалын эсрэг тэмцэхийн тулд орон нутгийн МЭЧ-ний журмыг даган мөрдөж байгаа бөгөөд Хонг-Конг 1996 оноос энэ хуулийг мөрдөж байна. Индонези, Малайз, Кампучийн иргэний нийгмийн төлөөлөгч нар энэ хуулийг хэрэгжүүлэхийг төрөөсөө хүчтэй шаардаж байна. Хэдийгээр Узбекистан, Тажикстан улсууд энэ хуулийг хэрэгжүүлж эхэлсэн ч гэсэн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсууд, Төв Азид энэ эрх зэрэглэл мэт л байна. Киргизстанд засгийн газар өөрчлөгдсөний дараа, Мэдээлэл, Соёл, Спортын Яам 2005 оны 10 дугаар сард МЭЧ-ний хуулийн төсөл дээр нэн даруй ажиллаж эхэлнэ гэдгээ зарласан билээ.

Ойрхи Дорнодод ганцхан Израйл улс л энэ хуулийг хэрэгжүүлж байгаа. Иордан, Палестин улсууд энэ хууль дээр ажиллаж, Марокко, Египет улсууд анхан шатны ахиц гарч байна. Африк тивд энэ хууль хэрэгжилт их удаашрилтай явагдаж байна. Хөгжлийг дэмжигч байгууллагууд Африкийн улс орнуудыг авилгалын МЭЧ-ний хуультай болгох талаар ихээхэн шахалт үзүүлсээр ирсэн боловч хуучин үеийн Албан Ёсны Нууцын тухай Акт одоо болтол бат бөх хэвээр байна.

Өмнөд Африкийн Мэдээлэл Авах Боломжийг Дэмжих Акт (РАИА) дэлхийн бусад адил хуулиудтай харьцуулахад хамгийн дэвшилтэй хууль болж чадсан юм. Энэ хууль хувь хүний эрх ашгийг хамгаалахын тулд хувь хүмүүсээс мэдээлэл шаардах эрхийг хангаж өгсөн юм. Харамсалтай нь энэ хууль хангалтгүй санхүүжилт, хэрэгжүүлэлтээс шалтгаалан зогсонги байдалд орсон билээ.

Ангол 2002 онд Португалийн хуулин дээр суурилсан хуулийг баталсан боловч хэрэгжүүлж эхлээгүй байна. Зимбабвэд батлан хэрэгжүүлж байгаа Мэдээлэл Авах Боломж болон Хувийн Нууцыг Хадгалах гэсэн нэртэй хууль хэвлэл мэдээллийг нухчин дарахад ашиглагдаж байна. Хамгийн сүүлд 2005 оны 5 сард Угандын Парламент МЭЧ-ний хуулийг баталсан нь саяхнаас хэрэгжиж эхэллээ. Кени, Нигерийн удирдагч нар энхүү хуулийг ойрын ирээдүйд хэрэгжүүлэхийн төлөө шамдан ажиллаж байна. Мөн түүнчлэн энэ хуулийг хэрэгжүүлэхийн төлөө олон орон чармайж байгаа бөгөөд ялангуяа Хамтын Нөхөрлөлийн гишүүн орнууд энэ тал дээр ихээхэн анхаарал хандуулж байна.

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТҮГЭЭМЭЛ АСУУДЛУУД

Дэлхийн улс орнуудад дагаж мөрдөгддөг МЭЧ ихэнх хуулиуд өөр хоорондоо төсөөтэй байдаг. Уг төсөөтэй байдал нь тухайн улс өөрийн МЭЧ-ний тухай хуулиа боловсруулан гаргахад, МЭЧ-ний хуулийг бусад орноос түрүүлж батлан гаргасан цөөн улс орнуудын хуулийг загвар болгон ашигладагтай холбоотой. Эдгээр улсуудаас АНУ-ын МЭЧ-ний хуулийг хамгийн их нөлөө бүхий хэмээн үздэг. Канад, Австрали зэрэг улсуудын хувьд, муж аймгийн болон улсын хэмжээний хуулиудаа Вэстминстерийн уламжлал бүхий улс орнуудын хуулин дээр түшиглэн боловсруулан гаргасан байдаг.

Сүүлийн үед МЭЧ-ний тухай хуулиудад нэлээд их хэмжээний шинэчлэл хийх болсон. Хууль сахиулах эрх бүхий мэдээлэл хариуцсан төрийн төлөөлөгч, олон нийтийн сонирхолын сорил, олон нийтийг хамрах хүрээ зэрэг хуучин хуулиудад тусгагдаж байгаагүй заалт, зүйлүүдийг шинэ хуулиудад нэмж оруулах болсон. Урьд өмнө нь батлагдсан хуучин хуулиудад ч мөн холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг хийх, дээрх заалтуудыг нэмж оруулж байна.

Хуульд хамаарагдах этгээд

Ихэнх МЭЧ-ний тухай хуулиудад орчин үеийн төрийн тогтолцооны гүйцэтгэх болон захиргааны албан тушаалтан, хуулийн этгээдүүдийг өргөнөөр тусгасан байдаг бөгөөд үүнд эрүүл мэнд, байгаль орчин, хууль эрх зүй, зэвсэгт хүчин, харилцаа холбоо, зам тээврийн зэрэг чиглэлээр хуулийн хэрэгжилтийг үндэсний болоод орон нутгийн хэмжээнд хариуцдаг яам, агентлагууд багтдаг байна. Зарим тохиолдолд шүүх болон хууль тогтоох байгууллагуудыг ч мөн уг хуулинд хамааруулан оруулсан байдаг.

Гол нь тус хуулинд төрийн үйл ажиллагаа, функцуудыг хэрэгжүүлж буй хуулийн болон нийтийн аливаа этгээдүүдийг оновчтой тодорхойлон, хуулинд тусган оруулж өгсөн байвал зохих юм. Португаль улсын төрийн холбогдолтой баримт бичгийн санд нэвтрэн орох тухай хуулинд “тус хуулийн дагуу төрийн болоод автономит засаг захиргааны аливаа нэгжийн удирдлагад ажиллаж буй этгээд, албан байгууллага, олон нийтийн институт, холбоод, орон нутгийн засаг захиргааны нэгж, орон нутгийн холбоод, нийгэмлэгүүд, болон олон нийтийн эрх бүхий байгууллагууд мэдээлэл хүсэх эрхтэй” хэмээн заасан байна.

Ирланд зэрэг улсын хувьд холбогдох бүртгэлийн хуудсыг боловсруулан гаргаж өөрийн хуулиуддаа хавсарган өгдөг нь тухайн хуулинд хамрагдаж буй этгээдүүдийн тодорхой жагсаалтыг бий болгоход чиглэсэн аж. Өөрөөр хэлбэл тухайн хуулинд ямар албан байгууллага, хуулийн этгээдүүд хамааралтай, ямар нь хамааралгүй болохыг уг бүртгэлээс тодорхой харж болно. Нөгөөтэйгүүр уг арга өөрийн гэсэн дутагдлуудтай. Тухайлбал тус бүртгэлд ямар нэгэн хуулийн этгээдийг шинээр зааж оруулах, хуулийн этгээдийн нэр нь өөрчлөгдөх, үйл ажиллагааны зорилго, бүтэц, чиглэл нь өөрчлөгдөх тохиолдол бүрт тус бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг парламентаар аль эсвэл холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэх болдог нь уг процессыг сунжруулдаг талтай. Цаашлаад төрийн зүгээс тухайн хуулинд шинэ этгээдийг нэмж оруулахаас татгалзвал мөн л хүндрэлтэй асуудлуудыг үүсдэг. Ирланд улсын холбогдох хуулинд Garda Siochбна (цагдаа) –г тусгаагүй байдаг. Харин Канад улсын хувьд, мэдээллийн санд нэвтрэх эрхийг хувийн хэвшлийн болон шинээр байгуулагдсан олон байгууллагад өгсөн нь нэлээд хэмжээний маргаан, санал зөрөлдөөнийг үүсгээд байгаа юм.

Зарим цөөн улс орны хувьд нууц мэдээлэл эзэмшиж буй этгээдүүдийг тус хуулинд зориудаар үл хамааруулах практик тохиолддог. Тухайлбал Их Британи болон Энэтхэг улсад мэдээллийн тухай хуулийн хамрах хүрээ хэсэгт аюулгүйн болон тагнуулын алба, газруудыг тусгаж оруулаагүй байна. Тухайн этгээдүүдийг хуулинд тусган оруулаагүй байх асуудал нь холбогдох этгээдүүдийн эзэмшиж буй буюу тэдний мэдэлд буй мэдээллийн нууц байдалтай холбоотой. Мөн тус хуулинд дээрх этгээдүүдийн үйл ажиллагааг тусгадаггүй нь ямар нэгэн этгээдийн бий болгосон байгаль орчны холбогдолтой аюул гэх мэт нууц мэдээлэл алдагдах, буруу замаар ашиглахаас сэргийлэх сонор сэрэмжийн механизм болж байгаа юм. Түүнчлэн, тэдний эзэмшиж, хадгалаж буй ихэнх мэдээлэл гол төлөв өдөр тутмын асуудлууд өөрөөр хэлбэл оффисын зориулалттай тавилга тоног төхөөрөмж худалдан авсан тухай, кредит карт ашигласан болон албаны машин тэрэг ашигласан тухай мэдээллүүд өргөн тохиолддог учраас тэдгээр хүмүүсийг хуулинд заан оруулдаггүй. Гэхдээ нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс тухайн этгээдийг хуулинд хамруулан оруулж, хамруулан оруулахдаа шаардлагатай бол мэдээллийн санд нэвтрэн орох эрхийг хязгаарлах байдлаар зааж өгөх нь илүү зохимжтой байх болно.

Холбооны болон хуваагдмал төрийн систем, зохион байгуулалт бүхий улс орнуудын хувьд хууль хэрэгжүүлэх үндэсний хэмжээний байгууллагын зүгээс тухайн мэдээллийн эрхийг дангаар эзэмшиж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрт холбогдох тусгай хуулиудыг батлан хэрэгжүүлэх практик илүү зохимжтой. Эхлээд эдгээр тусгай хуулиудыг практик дээр туршиж үзээд боломжийн хэмээн үзсэн тохиолдолд үндэсний хэмжээний хуулиудад багтаан оруулах нь зүйтэй. Үүний адилаар тусгай заалт зүйлүүдийг үндэсний хэмжээний хууль тогтоомжуудыг батлан гаргахаас өмнө туршин үзээд батласан байдаг. 1982 оноос хойш Япон улсад ойролцоогоор орон нутгийн засаг захиргааны 3,000 гаруй нэгж байгууллага өөрийн хууль тогтоомжоо батлан гаргасан. Орон нутгийн хэмжээнд батлан гаргасан эдгээр хуулиудыг хэрэгжүүлснээр үндэсний хэмжээний хуулиудыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжтой болсон хэмээн үздэг. АНУ-ын тухайд холбооны улсын бүх 50 муж улс өөрсдийн нээлттэй засаглалын тухай хуулиудаа батлан гаргасан бөгөөд эдгээр хуулиудын заримыг аль 19-р зууны эцэс, 20-р зууны эхэн үед буюу Холбооны улсын хууль, тогтоомжууд бий болохоос өмнө батлагдан гарч өдийг хүрсэн байна.

Шинэ Зеланд болон Их Британи зэрэг улсад тухайн орон нутгийн харьяа хувийн хэвшлийн байгууллагуудын мэдэлд буй мэдээллийг авах эрхийг тэдгээр улсын үндэсний хэмжээнд мөрдөгддөг хуулиудаар дамжуулан олгосон байдаг. Харин бусад нэлээд олон тооны үлс оронд хувийн хэвшлийн мэдэлд буй мэдээлэлд нэвтрэх эрхийг зохих хэмжээнд хязгаарласан байдаг. Тухайлбал Өмнөд Африкийн улсад мэдээлэл авах эрхийг дэмжих хуулиар хувь хүмүүс болон төрийн албан хаагчид шаардлагатай нөхцөлд аливаа хувийн хэвшлийн байгууллагаас холбогдох мэдээллийг хүсэх, шаардах эрхийг олгосон байдаг. 2004 онд гарсан Антигуа ба Барбуда улсын Мэдээллийн Эрх Чөлөөний тухайн хуулинд мөн энэ эрхийг заан оруулсан байдаг. Харин Дани улсын хувьд Төрийн Захиргааны Мэдээллийн Санд Нэвтрэх тухай хуулиар иргэд байгалийн хий болон эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудаас мэдээлэл авах эрхтэй байдаг.

Дэлхийн 50 гаруй улс оронд даган мөрдөгдөж байдаг мэдээллийн нууцыг хадгалах, хамгаалах тухай хуулиар олон нийтийн болон хувийн хэвшлийн аливаа байгууллагын мэдэлд буй хувь хүнтэй холбоотой мэдээлэл авах, тухайн мэдээлэлд засвар оруулах эрхийг хувь хүн, иргэдэд олгосон байдаг⁴⁵. Харин нэлээд олон улс орны батлан гаргасан байгаль орчныг хамгаалах тухай ихэнх хуулинд зааснаар аливаа аж ахуйн нэгж компани бүр өөрийн үйл ажиллагаатай холбоотой, байгаль орчин болон ард иргэдийн эрүүл мэндэд учирч болзошгүй хор уршиг, нөлөөллийн талаарх мэдээллийг нийтэд хэвлэн мэдээлэх ёстой байдаг.

Олон улсын этгээдүүд

Олон улсын төрийн байгууллагууд тухайн улсын төрийн бодлогыг боловсруулан гаргахад маш их үүрэг гүйцэтгэдэг хэдий ч тухайн улсын мэдээлэл авах эрхэд эерэг бусаар нөлөөлөх асуудал гардаг. Тухайн процесст нэвтрэн орох эрхийг иргэдэд олгосон орон нутгийн болон үндэсний хэмжээний шийдвэрүүдийг өнөө үед илүү нууцлаг бөгөөд дипломат нөхцөл байдалд оруулан гаргаж байгаа нь иргэдийн мэдээлэлд авах эрхийг хязгаарлаж байна. Шинэ Зеланд, Австрали зэрэг улсад хүнсний аюулгүй байдлын талаарх төрөөс баримтлаж буй бодлогыг тухайн улсын Албан Мэдээллийн тухай хуулинд хамааралтай бус хоёр талт тусгай хорооноос боловсруулан гаргадаг. Европын орнуудын жишээнээс харахад, 2003 онд болсон онгоцны сүйрлийн өмнөхөн Европын Иргэний Агаарын зөвлөгөөний гишүүн орнуудад хориглосон аюулгүй бус агаарын нийслэгийн талаарх мэдээллийг нуусан явдал гарсан. Нууц ангиллын мэдээллийг хамгаалах НАТО-гийн батлан гаргасан стандартуудын дагуу тус байгууллагын гишүүн бүх орон энэхүү стандартыг мөрдөж, улс бүр холбогдох хууль тогтоомжыг батлан гаргах ёстой боловч одоогоор холбогдох мэдээллүүдийг нууц ангилалд оруулаагүйгээс гадна нийтэд зарлаагүй хэвээр байна.

Зүтгэлтнүүд Дэлхийн Худалдааны Байгууллага, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан зэрэг байгууллагуудыг өөрийн үйл ажиллагаатай холбоо бүхий мэдээллийг нийтэд зарлан мэдээлэхийг шаардсаар ирсэн ч тэд төдийлөн амжилтанд хүрээгүй байна⁴⁶. Олон улсын хэмжээнд хамгийн өндөр хөгжсөн байгууллага гэгддэг Европын Холбооны хувьд тус байгууллага засгийн газар хоорондын ямар ч байгууллагаас илүү мэдээлэлд нэвтрэх хөгжингүй дэглэм, зохион байгуулалтыг бий болгосон боловч гишүүн орнуудтай нь харьцуулахад мэдээлэлд нэвтрэх байдал нэлээд хязгаарлагдмал байсаар байна.

Ямар мэдээлэл авах боломжтой вэ

⁴⁵ EPIC болон Прайвэси Интэрнэшл , Хувийн Нууц болон Хүний Эрх 2004

<http://www.privacyinternational.org/survey/>

⁴⁶ вебсайт <http://www.freedominfo.org/ifti/index.htm>

Тухайн улсын Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хуулиудад төрөл бүрийн нэр томьёо ашиглан, хүмүүс ямар мэдээллийг авах эрхтэй гэдгийг тайлбарласан байдаг. Хуучин хуулиудын хувьд ерөнхийдөө баримтын бүртгэл, албан баримт бичиг, файлуудад нэвтрэх зэргийн талаар заасан байдаг бол шинээр батлагдан гарсан хуулиудад мэдээллийн эрх хэмээн өргөнөөр заасан байдаг. Ямар мэдээлэл хаана хэрхэн хадгалагдаж байгаагаас үл хамааран бүхий л мэдээллийг хамруула ойлгох байдал өнөөгийн хуулиудад түгээмэл байгаа боловч бодит амьдрал дээр тийм ч их ялгаатай зүйл мэт харагдахгүй байгаа юм. Гэсэн хэдий ч Швед зэрэг улсуудад эцсийн бус төсөл хэлбэртэй, бэлтгэлийн шатандаа явж буй аливаа баримт бичгийг “албан баримт бичиг” гэдэг категорит оруулдаггүй, учраас мэдээллийн хэт их бөөгнөрөл бий болдоггүй. Энэтхэгийн Мэдээллийн Эрхийн тухай хуулийн дагуу хувь хүмүүс, иргэд нийтийн хоол хүнстэй холбоотой мэдээлэл, мөн замын барилга угсралтын ажилд ашиглаж буй түүхий эд материалын талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас шаардан авахыг зөвшөөрсөн байдаг.

Ерөнхийдөө мэдээлэлд авах эрх гэдгийг зөвхөн бүртгэгдсэн мэдээллүүдэд хамруулан ойлгож байна. Ийм байдлын улмаас аман хэлбэрээр дамжуулсан, хүргэсэн мэдээллийг (албан уулзалтын үеэр гэх мэт) бүртгээгүй орхигдуулах, шийдвэр гаргалтанд ашиглаж болох байсан мэдээллийг бүртгээгүй орхигдуулсан зэрэг явдлаас завсардалт үүсэх тохиолдол бий. Ийм асуудал үүсгэхгүйн тулд мэдэгдэж буй аливаа мэдээллийг авах боломжтой болгохыг шаарддаг байх хэрэгтэй юм.

Дани улсад тухайн албан тушаалтан, тухайн агентлаг газрын шийдвэр гаргалтанд чухал ач холбогдол бүхий мэдээллийг аман хэлбэрээр авч байгаа тохиолдолд холбогдох мэдээллийг заавал бичиж, тэмдэглэл хөтлөх үүрэгтэй байдаг. Шинэ Зеландын хуулинд тухайн агентлаг, газарт мэдэгдэж буй боловч бүртгэгдээгүй мэдээллийг иргэн хүсвэл уг мэдээллийг заавал бүртгэлд оруулсан байх шаардлагатай хэмээн заасан байдаг. Тус арга барилаар ажилласнаар ирээдүйн шийдвэр гаргалтанд тухайн мэдээллийг ашиглаж болохоос гадна тухайн албан тушаалтан зохих мэдээллийг нийтэд гарган, мэдээлэхээс зайлсхийх, мэдээллийг орхигдуулах боломжийг хязгаарлан, баримт бичгийн зохистой сан, бүртгэл хөтлөлтийг хөтлөн хадгалах боломжийг олгодог.

Мэдээллийг хэн авч болох вэ

Сүүлийн үед ихэнх улс орнуудад тухайн этгээдийн ашиг сонирхол, иргэнийн байдал, харьяа засаг захиргаанаас үл хамааран хүн бүр хэрэгцээтэй мэдээллээ авах хүсэлтээ гаргахыг зөвшөөрч байна. Финланд зэрэг улсад мэдээлэл хүсч буй хүмүүсийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх үүднээс мэдээлэл хүсч буй тухайн хүн өөрийн нэрээ зарлахгүй байхыг зөвшөөрдөг. Өндөр шаардлага тавин, хязгаар зааж өгөх нь хүний эрхийг ноцтойгоор зөрчих аюултай болохыг Энэтхэгийн зарим албан тушаалтнуудын туршлагаас харж болно. Тэд ард иргэдийн нэлээд нь паспорт, иргэний үнэмлэх, биеийн байцаалт зэрэг бичиг баримтгүй гэдгийг мэдсээр атал мэдээлэл хүссэн хүмүүсийг иргэний харьяаллын баримт бичгээ үзүүл, нотлох баримт бичгийг заавал авчир хэмээн тодорхой шаардлагагүйгээр дарамтлан, хүмүүст хүндрэл чирэгдэл үзүүлсээр байна.

Үл Хамаарах нөхцөл

Мэдээллийн Эрх Чөлөөний тухай ихэнх хуулиудад нийтэд түгээхгүй мэдээллийн ангиллуудыг тодорхойлсон заалт зүйлүүд багтсан байдаг. Холбогдох ихэнх хуульд хамаарахгүй түгээмэл тохиолдлыг заасан байдаг. Эдгээр мэдээлэлд үндэсний аюулгүй байдал болоод олон улсын харилцаа холбоог хамгаалах, хувь хүний нууц, худалдааны нууц, хууль сахиулах болон нийтийн амгалан байдлыг сахиулах, нууцаар хүлээн авсан мэдээлэл, болон улсын дотоод яриа хэлэлцээр зэргийг хамруулсан байна. Олонх парламентын тогтолцоонд засгийн газраар батлуулахаар өгсөн баримт бичиг болоод төрийн уулзалт хурлуудын тэмдэглэлийг тодорхой хугацааны дараа нийтийн хүртээл болгодог. Ирланд улсад тухайлбал төрийн мэдээллийг нийтэд хүргэх асуудал 10 жилийн

дараа яригддаг. Харин Шинэ Зеландын хувьд засгийн газрын баримт бичгүүдийг ямар нэгэн хожимдолгүйгээр хүсэлтийн дагуу нийтэд гаргадаг байна.

Ихэнх хуулиудын дагуу тухайн мэдээллийг нийтийн хүртээлд үл хамааруулах нөхцөлд оруулахаас өмнө тэрхүү мэдээлэл нийтэд хүрснээр ямар хор хохирол учруулж болохыг зарим нэгэн заалтын хүрээнд шалгах шаардлагатай байдаг. Хор хохирлын сорилыг нууцлах шаардлагатай мэдээллийн төрлөөс хамааруулан янз янзаар хийж болно. Хувийн нууц, дотоод шийдвэр гаргалтын нууц, мөн үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудад ерөнхийдөө нууцлалын хамгийн өндөр зэрэглэлийг өгдөг. Үндэсний хэмжээний нэлээд олон хуулинд “олон нийтийн ашиг сонирхлын сорил” гэх зүйлийг оруулж өгдөг. Энэ заалтаар эрх бүхий олон нийтийн байгууллага болон холбогдох хяналт шалгалтын байгууллагууд нь олон нийтийн сонирхлын дагуу тухайн мэдээллийг нийтэд гаргах болон тухайн мэдээллийг нуух асуудлыг тэнцвэржүүлэх үүрэгтэй байдаг. Энэ нь тухайн мэдээллийг олон нийтэд гаргаснаас үүдэх хор хохирол болон олон нийт тухайн мэдээллийг авснаар ямар хор хохирол учирч болохыг үл харгалзан тухайн мэдээллийг нийтэд гаргахыг зөвшөөрдөг.

Уг зарчмыг ихэнхдээ зохисгүй үйлдэл, авилгалыг нийтэд илчлэх, аль эсвэл хувь хүмүүс болон байгаль орчинд учирч болох хор хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг. Зарим улс орнуудад энэхүү зарчмыг олон нийтийн ямар нэгэн эрх ашгийг хөндсөн төдий л хэрэгжүүлэн тухайн мэдээллийг нийтэд гаргадаг байна. Ихэнх хуулиудын дагуу тухайн мэдээлэлтэй холбоотой хор хохирол нэгэнт багассан нөхцөлд тус мэдээллийг нийтэд гаргахыг зөвшөөрдөг. Зарим хуулиудын хувьд мөн цаг хугацааны хязгаарыг зааж өгдөг. Тухайлбал Мексик улсын Холбооны Ил Тод, Нээлттэй байдлын тухай хуулинд мэдээллийг үл хамааруулахдаа зөвхөн 12 жилийн хугацаанд байдаг байна.

Сүүлийн үед нэлээд олон МЭЧ-ний тухай хуульд зарим төрлийн мэдээллийг нууцлах асуудлыг онцгойлон хориглох болсон. Азербайжан улсын хуулинд олон нийтийн санал асуулга, тэтгэлэг, нөхөн төлбөр, статистикийн мэдээ баримт гэх мэт мэдээллийг нуух ёсгүй учраас холбогдох мэдээллүүдийн жагсаалтыг гаргасан байдаг. Мексик улсын холбооны ил тод, нээлттэй байх болон мэдээлэл авах тухай хуулинд “Хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн болоод хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдсэн эсэхийг мөрдөх явцад тухайн мэдээллийг нууц хэмээх ангилалд оруулахгүй” хэмээн заасан байдаг. НҮБ-ийн Европын Эдийн Засгийн Хорооны байгуулсан гэрээгээр байгаль орчны холбогдолтой мэдээллийг нуух гэсэн шалтгаанаар тухайн арилжааны мэдээллийг нууцлах эрхийг хязгаарлаж өгсөн байдаг.

Гомдлыг шийдвэрлэх, хэрэгжилтийг хянах

Тухайн хуулийн хэрэгжилтийг сахиулах, холбогдох гомдлыг шалгах, хяналт тавих хэд хэдэн төрлийн механизм үйлчилдэг. Эдгээр механизмуудад захиргааны шийдвэр, шүүхийн шийдвэр болон бие даасан институтын хяналт орох бөгөөд ийм байдлаар хийгдсэн хяналтын үр нөлөө өөр өөр байдаг. Мэргэжилтнүүдийн үзэж буйгаар бие даасан институтын хяналт хамгийн үр дүнтэй аж.

Ихэнх улсуудын хувьд гомдол шийдвэрлэх эхний шат нь байгууллагын дотоодын бүтцээс эхэлдэг. Энэ нь хүсэлт гаргасан тухайн байгууллагын дээд албан тушаалтанд гомдол гаргах байдлаар хийгдэнэ. Энэ нь практик талаасаа янз бүрийн үр дагавартай. Нэг талаас тухайн шийдвэрийг хянах хямд төсөр бөгөөд цаг хугацаа хэмнэсэн хэлбэр боловч нөгөөтэйгүүр ихэнх орнуудын туршлагаас харвал иймэрхүү дотоод систем нь мэдээлэл авах эрхийг хязгаарлахыг өөгшүүлэх, мэдээлэл авах боломжийг өргөжүүлэх бус харин түүнээс илүүтэйгээр удаашрал, саатлыг бий болгох хандлагатай байдаг. Их Британид 2005 онд байдлаар төрийн байгууллагуудын дээд албан тушаалтанд гаргасан гомдлын 77 хувийг буцаасан байлаа.

Нэгэнт дотоод хяналтын систем буюу дээл албан тушаалтанд гомдол гаргасан нөхцөлд, хийх ёстой дараагийн шат нь хөндлөнгийн байгууллагад хандах юм. Дэлхийн 20 гаруй улсад, омбудсмен (төрийн байгууллагын талаар гомдол гаргасан хувь хүмүүсийн гомдлыг авч хэлэлцэх эрхтэй төрийн томилсон хүн)-нд эрх мэдлийнх нь хүрээнд тухайн төрийн байгууллагад хяналт хийлгэх тухай хүсэлтийг гаргаж болно. Гэхдээ омбудсменд заавал биелүүлэх шийдвэр гаргах эрх байхгүй хэдий ч ихэнх улс орнуудад тэдний өгсөн дүгнэлт нэлээд нөлөө бүхий байдаг учраас ерөнхийдөө тэдгээрийг дагаж мөрдөх болдог.

Бие Даасан Мэдээллийн Хороо байгуулах асуудал өнөө үед өсөн нэмэгдэж буй хандлага болоод байна. Тус хороо нь Парламентийн нэг хэсэг байж болох буюу аль эсвэл төрийн өөр нэгэн байгууллага буюу засгийн газрын бие даасан хэсэг (тухайлбал Тайланд улсад) аль эсвэл бүрэн бие даасан төрийн нэгж байгууллага байж болно. Тус тайланг бичих явцад дэлхийн 22 улсад төрийн уг нэгжийг байгуулаад байна. Их Британи, Герман, Швейцари, Словени зэрэг нэлээд олон оронд Мэдээллийн Эрх Чөлөөг хариуцсан хороог Мэдээллийг Хамгаалах Үндэсний Хороотой нэгтгэн байгуулсан байна. Герман болон Канадын хувьд мөн ийм байдлаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн. Гэхдээ уг арга барилыг саяхан Канадын засгийн газрын холбогдох хорооноос татгалзуулан байна. Ирландад мөн мэдээллийн төлөөлөгч болон ерөнхий омбудсмен гэх нэг хүн байдаг.

Тус хорооны эрх мэдэл болон функцууд улс орон бүрт өөр өөр байж болно. Канад, Франц зэрэг зарим улсад уг хороо нь омбудсмены адил эрх мэдэлтэй байдаг. Словени, Серби, Ирланд, болон Их Британийн хувьд тус хороо нь хүмүүсээс ирүүлсэн гомдлын дагуу болон зарим онцгой нөхцөл байдалд сайдуудын холбогдох шийдвэрийг гаргах хязгаарлагдмал эрх бүхий байна. Мөн Мэдээллийн төлөөлөгч нь санал гомдлын мөрөөр ажиллах үүрэгтэйгээс гадна системийг ерөнхийд хянах, сургалт зохион байгуулах, өөрчлөлтүүдийг санал болгох, олон нийтэд ойлголт мэдлэг өгөх зэрэг бусад чиг үүрэг мөн хүлээн ажилладаг. Антигуа болон Барбудад томилогдсон төлөөлөгч нарт мэдээлэгч нараас мэдээлэл авахыг зөвшөөрдөг.

Зарим орнуудад тусгай шүүхийг үүсгэн байгуулж гаргасан шийдвэрүүдийг авч хэлэлцдэг. Гэхдээ уг мэргэжилтнүүдийн ажлын хэсэг нь улсын шүүхтэй харьцуулбал арай албан бус хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах хэдий ч мэргэжлийн зориулалтынхаа хувьд санал гомдлыг илүү нухацтай авч хэлэлцэн шийдвэрлэх ёстой юм. Австралид л гэхэд захиргааны шүүхээр жил бүр олон зуун санал гомдлыг авч хэлэлцдэг. Харин Япон улс дахь Мэдээллийг Нууцлах Байдлыг Хянах Хороо нь агентлагуудын анхан шатны шийдвэрүүдтэй холбоотой гомдлууд дээр ажилладаг. Гэхдээ холбогдох агентлагуудын зүгээс тухайн хэргийг Хянах Хороогоор хэлэлцэх асуудлыг хойшлуулах боломжтой байдгаас тус улсын хувьд нэлээд олон хэргийг хойшлуулсан тохиолдлууд бий. Ямайкийн хувьд хэргийг удаан хугацаагаар хойшлуулсан болон хэт албархуу дүрэм журмаар асуудал шийдвэрлэх ажил явагдсан хэмээх асуудлаар хэрэглэгчд мөн гомдол гаргах боломжтой. Их Британийн тухайд гэвэл тус улс нь холбогдох хороо болон мэргэжилтнүүдийн хянах ажлын хэсгийг хоёуланг нь ажлуулдаг ганц улс юм. Тусгай шүүх трибунал нь хянах системд эерэг үүрэг гүйцэтгэн оролцоор ирсэн нь хэд хэдэн хэргийг тус улсын Мэдээллийн Хорооноос няцаан хүлээн авахгүй байсан явдлыг ил тод болгосон явдлаас харагдаж байна.

Ихэнх улсад эцсийн шатны хяналтыг үндэсний хэмжээний шүүхэд хандан гомдлыг шийдвэрлэх байдлаар хийдэг. Шүүхийн зүгээс холбогдох бүртгэлүүдтэй танилцаж, заавал биелүүлэх ёстой шийдвэрийг гаргана. Мэдээллийн хороо бүхий зарим улсад тухайн шүүхийн шүүн таслах эрх мэдлийг зарим хуулийнхаа заалтуудаар хязгаарласан байдаг. АНУ болон Болгар зэрэг улсуудад шүүх нь зөвхөн хөндлөнгийн байдлаас үнэлгээ дүгнэлт өгөх байдлаар ажилладаг нь харьцангуй үр дүн багатай хэдий ч ингэж ажиллах нь хэрэглэгчдийн зүгээс хэлэлцэх асуудлын өртөг зардал болон хугацаа хойшлуулсантай холбогдуулан гарах гомдол хэт их гарахаас сэргийлдэг.

Шүүх нь мөн агентлагуудын хувьд ерөнхийдөө хүндэтгэлтэй харьцдаг нь нэн ялангуяа үндэсний аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл бүхий асуудал дээр тод илэрдэг.

Хариуцлага

Мэдээллийн Эрх Чөлөөний тухай ихэнх хуулиудад тухайн мэдээлийг хууль бусаар нуун дарагдуулсан аливаа эрх бүхий олон нийтийн байгууллага мөн холбогдох ажилтан албан хаагчдад хариуцлага хүлээлгэх тухай заалт байдаг. Түгээмэл тохиолдох хэргүүдийн хувьд ямар нэгэн төрийн байгууллага, аль эсвэл албан хаагч хүссэн мэдээллийг ямар нэг үндэслэлгүйгээр өгөхөөс татгалзсан, аль эсвэл холбогдох баримт бичгийг засч өөрчлөх, устгах явдлууд байж болно.

Хариуцлагыг тухайн байгууллагын эсрэг авахаас гадна мөн захиргааны болон эрүүгийн арга хэмжээг тодорхой албан тушаалтан ажилтнуудын хувьд авч болдог. Ихэнх хуулиудад заасан хариуцлагын тухайд торгуул ноогдуулах, хууль дүрэм журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд хорих ял оноох явдал ч байдаг. Польш улсын Олон Нийтийн Мэдээлэл Авах тухай хуулинд “заасан үүрэг хариуцлагын дагуу олон нийтийн мэдээллийг хүсэлтийн дагуу өгөөгүй аливаа этгээдийг торгуул ноогдуулах, эрх чөлөөг нь хязгаарлах, аль эсвэл нэг хүртлэх жилийн хугацаагаар хорих ял оноох хүртэлх арга хэмжээ авна” хэмээн заасан байдаг.

Хариуцлага нь аливаа хуулийн зайлшгүй нэгэн хэсэг болж байдаг нь аливаа дагаж мөрдөхгүй байх нь хэр ноцтой зүйл болохыг харуулах үзүүлэлт юм. Нөгөөтэйгүүр төрийн байгууллагуудын хувьд ажилтан нь холбогдох ерөнхий дүрэм журам, бодлогыг үл дагасан нөхцөлд шаардлагатай арга хэмжээ авах тал дээр хойрго ханддаг нь ажиглагддаг. Хорих ял оноох асуудал дээрх арга хэмжээ шийтгэлийн дотроос нэлээд ховор гардаг. Өнгөрсөн жилүүдэд, АНУ –д тухайлбал орон нутгийн түвшинд хорих ял оноох явдал маш цөөн гардаг. Энэтхэгт Мэдээллийн төлөөлөгчдийн зүгээс хүссэн мэдээллийг өгөхөөс татгалзсан буюу Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу хүссэн мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй аливаа албан тушаалтан бүрт торгууль ногдуулж эхэлсэн. Төлөөлөгчид тухайн албан тушаалтныг байцааж, хүссэн мэдээллийг өгөөгүйн улмаас арга хэмжээ авах мэдсээр байж ямар учраас мэдээллийг олгоогүй тухай тогтоодог. Гомдол гаргагчийн гомдлыг барагдуулах зорилгоор мөн хүссэн мэдээллийг гаргаж өгөөгүй холбогдох байгууллага дээр арга хэмжээ авч болдог. АНУ-д тухайн мэдээллийг нуун дарагдуулах шаардлагагүй байсныг тогтоосон тохиолдолд шүүхээс гомдол гаргагч, хохирогчийн нэхэмжлэл, шүүхтэй холбоотой зардал төлбөрийг барагдуулах шийдвэр гаргадаг.

Заавал хэвлэн нийтлэх үүрэг

Мэдээллийн Эрх Чөлөөний тухай ихэнх хуулинд төрийн байгууллага, агентлагууд зарим төрлийн төрийн холбогдолтой мэдээллийг олон нийтэд идэвхтэйгээр тараан түгээх, гаргаж байх үүрэгтэйг заасан байдаг. Тодорхой төрлийн мэдээлэл гэдэгт төр, засгийн газрын бүтэц зохион байгуулалт болон функц албан тушаалын талаарх нарийвчласан мэдээлэл, хууль тогтоолын баримт бичгүүд, бодлогын баримт бичиг, тэдгээрийн төслүүд, баримт бичгийн загвар маягт болон шийдвэрүүд багтана. Сүүлийн үед батлагдан гарч буй Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хуулиудад тодорхой нэр төрлийн мэдээллийн жагсаалт оруулах болсон.

Мэдээллийг идэвхийлэн гаргах нь төрийн байгууллагуудын хувьд нэлээд ач холбогдол, үр өгөөжтэй байдаг. Өөрөөр хэлбэл мэдээлэл гаргах өгөх үүрэгтэй байгууллага албан тушаалтны хувьд өдөр дутмын шинж чанартай мэдээлэл авах хүсэлтэнд хариу өгөх түвэгтэй ажлыг нь хөнгөвчилж өгдөг гэсэн үг юм. Түүнээс гадна ийм байдлаар мэдээллийг нийтэд хүргэх нь холбогдох байгууллага албан тушаалтнуудын үйл ажиллагааны үр нөлөөтэй байдал сайжрахад шууд нөлөөлдөг хэмээн үзэж болно. Европын Холбооны Зөвлөл өөрийн 2003 оны жилийн

тайландаа тусгаснаар “Олон нийт шууд авах боломжтой баримт бичиг, мэдээллийн тоо өсч байгаа нь эргээд хүмүүсийн зүгээс баримт мэдээлэл авах хүсэл, эрэлт буурахад хүргэж байна⁴⁷” гэжээ.

АНУ-ын Хууль Зүйн Департаментаас 2002 онд төрийн агентлагуудад хийсэн шалгалтын тайландаа тусгаснаар олон нийтийн сонирхлыг ихээр татаж буй мэдээ баримтыг вэб сайтаар дамжуулан олонд хүртээмжтэй болгож байгаа нь иргэдийн зүгээс баримт мэдээлэл хүсэх явдлыг бууруулж байна хэмээжээ⁴⁸.

Цахим Мэдээллийн Эрх Чөлөө

Мэдээлэл авах бас нэгэн шинэ чиг хандлагын тухайд дурьдвал цахим хэлбэрээр мэдээлэл хүсэх, мэдээллийг олон нийтэд цахим системээр дамжуулан хүргэх хандлага өсөн нэмэгдэж байна. Нэлээд олон тооны үндэсний хэмжээнд мөрдөгддөг Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хуулинд төрийн агентлагуудыг өөрийн веб сайт, хуудсаараа дамжуулан тодорхой төрлийн мэдээллийг олон нийтэд хүргэдэг байх тухай заадаг болсон. Польш улсын Олон Нийтийн Мэдээлэл Авах тухай хуулинд олон нийтийн байгууллагууд өөрийн үйл ажиллагааны зарчим, бодлого, хууль эрх зүйн зохион байгуулалт, удирдлагын үйл ажиллагааны цар хүрээ, шийдвэр гаргалт, нийтийн өмч хөрөнгөтэй холбоотой нарийн мэдээллүүдийг Олон Нийтийн Мэдээллийн Бюллетень хэмээх вэб хуудсаар дамжуулан олонд түгээх үүрэгтэй хэмээн заасан байдаг. Харин Эстони улсын Олон Нийтийн Мэдээллийн тухай Хуулинд зааснаар бол үндэсний болон орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон олон нийтийн мэдээлэл эзэмшиж буй бусад байгууллагууд өөрийн нэр дээр вэб хуудас ажиллуулан, тухайн вэб хуудсан дээрээ гэмт хэрэг, эдийн засгийн холбогдолтой статистикийн баримт мэдээний өргөн хүрээтэй жагсаалтыг гаргадаг байх үүрэгтэй аж. Түүнээс гадна уг вэб хуудсаар дамжуулан агентлаг, газруудын хууль дүрэм журмын эмхтгэл, бүтэц зохион байгуулалт, албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолт, тэдний албан хаяг, мэргэжил боловсрол, цалингийн хэмжээ зэрэгтэй холбоотой мэдээллийг гаргахыг заадаг. Цаашилбал мөн вэб хуудсанд эрүүл мэнд, аюулгүй байдлын тухайн мэдээлэл, төсөв, төсөвлөлт, байгаль орчны байдал, төслийн баримт бичиг, тогтоол, төлөвлөгөө, тайлбар санамж бичиг зэргийг оруулсан байх ёстой. Анхаарах гол зүйл нь “тухайн вэб хуудсанд тавигдах мэдээллүүд цаг үеийнх байх ёстой буюу хоцрогдсон, үнэн бодит бус, хуурамч байж болохгүй” ажээ.

Европын Холбооны Зөвлөл өөрийн боловсруулан гаргаж буй ихэнх мэдээллээ шууд нийтэд хүртээмжтэй болгодог. Нийтэд гаргаж буй мэдээллийн тоонд мэдээлэл авах тухай хууль тогтоомжийн дагуу гарсан аливаа баримт бичиг, электрон бүртгэлд орсон аливаа баримт бичгүүд ордог байна⁴⁹. Дэлхийн олон оронд хийгддэг бохирдлын талаарх бүртгэл нь иргэд тухайн орон нутаг дахь аж үйлдвэрээс гарах хаягдал хүмүүсийн эрүүл мэндэд хэрхэн сөргөөр нөлөөлж болох тухай мэдээллийг вэб хуудсаар дамжуулан хүргэх боломжийг олгодог.

Орчин үед ямар нэгэн мэдээлэл хүсч буй хүн бүр электрон шуудан болон интернэтэд суурилсан мэдээлэл хүсэх маягт бөглөх замаар авах бүрэн боломжтой болоод байна. Турк улсад л гэхэд гол яамдууд нь цахим сүлжээг өргөнөөр ашиглан, холбогдох мэдээллийг нийтэд хүртээмжтэй болгосон. Өөрөөр хэлбэл, тухайн вэб хэрэглэгч он-лайнаар мэдээлэл авах хүсэлтээ гарган, хүсэлтийнхээ хариуг авах болмжтой. Мексикийн Sistema de Solicitudes de Informaciyn (SISI) хэмээх системийг Олон Нийтийн Мэдээллийн Холбооны Улсын Институт хариуцан ажиллуулдаг (IFAI) бөгөөд тус багууллагын гол үүрэг нь төрийн байгууллагуудад зориулан иргэдээс ирсэн мэдээлэл

⁴⁷ Хуулийг Хэрэгжүүлэх Зөвлөлийн Жилийн Тайланг үз. (E3) No 1049/2001

⁴⁸ АНУ-ын Хууль Зүйн Департамент 2002 оны жилийн МЭЧ-ний тухай тайлан
<http://www.usdoj.gov/oip/foiapost/2003foiapost31.htm>

⁴⁹ <http://register.consilium.eu.int/>

авах хүсэлтийг цахим хэлбэрт оруулан архивлан хадгалдах юм⁵⁰. Холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулснаар тус улсын холбооны мужууд өөрийн хүсэлтийн дагуу уг системийг ашиглах асуудлыг зөвшөөрсөн байна. Холбооны улсын Сонгуулийн Институттэй (FEI) байгуулсан бас нэгэн хэлэлцээрийн дагуу мексик дахь тус институтын аль ч салбараас мэдээлэл хүсэх боломжийг олгосон. Бичгээр болон амаар ирүүлсэн мэдээлэл авах аливаа хүсэлтийг системд бүртгэх бөгөөд ийм байдлаар бүртгэл хөглөснөөр Мэдээллийн Хорооны хүсэлт боловсруулах ажилд автоматжуулсан мониторинг хийх боломжийг бүрдүүлж чаджээ.

Мэдээлэгч

Сүүлийн жилүүдэд мэдээлэгчийг хамгаалах хуулийг батлан гаргаж буй улс орнуудын тоо нэмэгдэж байгаа бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 30 гаруй оронд мэдээлэгчдийг хамгаалах тухай тусгай хуулийг гарган мөрдөж эхлээд байна. Бусад улсуудын хувьд хөдөлмөрийн хууль, төрийн салбарын ажил эрхлэлтийн тухай дүрэм журам зэрэг бусад хууль тогтоомжоороо дамжуулан мэдээлэгчдийг хамгаалах арга хэмжээг авч байна. Их Британи, Өмнөд Африк, Гана, Канад, Япон, Шинэ Зеланд, АНУ зэрэг нэлээд олон тооны улсад мэдээлэгчийн тухай нэлээд нарийвчлалтай хуулийг батлан гаргаад байгаа ба уг хууль нь ерөнхийдөө үндсэн хоёр санааг агуулдаг. Нэгдүгээрт – урьдчилан сэргийлэх ажил буюу тухайн байгууллага дээр үйлдэгдэж буй авилга, зохисгүй удирдлагын гэх мэт сөрөг үйл ажиллагаа, үйлдэлтэй холбоотой мэдээллийг нийтэд зарлах мэдэгдэх явдлыг бодит ажил болгох буюу дэмжих замаар тухайн байгууллагын соёлыг өөрчлөх оролдлого хийх асуудал; хоёрдугаарт, тухайн мэдээлэл хүргэснээрээ аливаа шийтгэл, арга хэмжээ авахуулахаас үл эмээн тухайн мэдээллийг нийтэд ил тод гарган ирж буй хүмүүсийг хамгаалах, урамшуулах цогц зүйлийг агуулдаг байна.

Хэд хэдэн улсын мэдээллийн эрх чөлөөний тухай үндэсний хэмжээний хуулинд ч мөн мэдээлэгчдийг хамгаалах асуудал багтсан байдаг ба жишээлэхэд Швед улсын Хэвлэл Мэдээллийн Эрх Чөлөөний тухайн хуулиар төрийн албан хаагчдад төрийн тухайн нэгэн байгууллагын үйл ажиллагааг нэрээ илчлэх албагүйгээр шүүмжлэх үндсэн эрхийг өгсөн байна. 2002 онд Молдав улс, 2004 онд Антигуа ба Барбуда, 2005 онд Уганда, 2006 онд Македони болон Монтенегро зэрэг улс төрийн байгууллагын эсрэг мэдээлэл хүргэх асуудлыг агуулсан заалт бүхий нэлээд хэдэн шинэ хуулиудыг батлан гаргасан. Мөн Кайманы Арал улсын Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хуулийн төсөлд энэ асуудлыг оруулахаар хэлэлцэж байгаа юм. Гэхдээ эдгээр хуулийн дагуу тухайн мэдээлэгч төрийн албан хаагч байх тохиолдолд түүний эрх, эрх чөлөөг хуулиар хамгаалах бөгөөд мэдээлэл хүргэх асуудлыг хувийн холбогдолтой мэдээллийг бусдад зөвшөөрөлгүй өгсөн тохиолдолд авч хэлэлцэхээр зохицуулагдсан байдаг. Антигуа улсын хуулиар мэдээллийн төлөөлөгч нь зохисгүй үйлдэлтэй холбоотой мэдээллийг хүлээн авах үүрэг бүхий хуулийн этгээд байна хэмээжээ.

ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД

Мэдээллийн Эрх Чөлөөний Тухай Хуулийг батлан гаргах асуудал нь дөнгөж эхлэл нь учраас тухайн хууль ашиг тусыг хүртэхийн тулд юуны түрүүнд хуулийг хэрэгжүүлэх ёстой байдаг. Үүний тулд тухайн улсын төр засаг өөрийн дотоод соёлыг өөрчлөх ёстой бөгөөд үүнийг нь эргээд иргэний нийгмийн зүгээс хянадаг, мэдээлэл шаарддаг байх хэрэгтэй.

Ихэнхдээ төрийн зүгээс мэдээлэл хүргэхдээ хойрго, урт хугацаагаар хойшлуулан, шүүхээс хууль ёсны шаардлагуудыг сулруулах зэргээс үүдэн хэрэглэгчид итгэл найдвараа алдах, мэдээлэл авах хүсэлт гаргахаа больдог.

⁵⁰ <http://www.informacionpublica.gob.mx/>

Мэдээллийн тухай хуулиудаас ангид байх

Дэлхий дахинд түгэн дэлгэрч буй ил тод нээлттэй байх шахалт шахуу болж буй зүйлийн үр дүнд цөөн бус нэлээд хэдэн улс үндэстэн мэдээллийн эрх чөлөөний тухай нэр төдий хуулийг батлан гаргаж байна. Үүний нэгэн адилаар ЗХУ зэрэг захиргаадгалтын улс орнууд өөрийн үндсэн хуулиндаа хүний эрх, эрх чөлөөг өргөнөөр тусгаж эхлэн, зарим улсууд тэр бүү хэл Мэдээллийн Эрх Чөлөөний тухай хууль батлан гаргасан байна. Хамгийн бүдүүлэг гэх жишээг нэрлэвэл Зимбабве улсын Мэдээлэл Авах ба Хувийн Нууцыг Хадгалах тухай хууль бөгөөд тус хуулийн агуулга ба нэр хоёр нь зөрж байгаа нь сэтгүүлчдийн үйл ажиллагаанд чанд хатуу зохицуулалт тавьсан байдлаас харагдаж байна. Мөн энэхүү хуулийн дагуу тус улсын төр, засгийн газрыг үл дэмжсэн аливаа сонин хэвлэлийг хааснаар зогсоогүй тэр байтугай засгийн газартай хамтран ажиллах хүсэлгүй сэтгүүлч нэг бүрийг шоронд хорих, тус улсаас хөөн зайлуулах хүртэл арга хэмжээ авсаар ирсэн. Тус хуулийн мэдээлэл авах тухай заалт тус улсад хэрэгжих ямар ч боломжгүй байна. Учир нь мэдээлэл хүсэх зориг бүхий ямар ч хүнийг тус улсын засгийн газрыг дэмжигчид даруй мөшгин дарамталдаг.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хүний үндсэн эрх, эрх чөлөө тийм ч их дэмждэггүй улс орнуудад мэдээллийн эрх чөлөөг тогтоох нь хүндрэлтэй асуудал. Гэсэн хэдий ч Узбекистан болон Таджикистан улсад Мэдээллийн Эрх Чөлөөний тухай Хуулийг батлан гаргасан. Иймэрхүү улс орнуудад мэдээллийн эрх чөлөөний үндсэн зарчмын үнэ цэнийг бууруулах хууль гарган зарим хуулийн хэрэгжилтэнд саад тогторыг учруулдаг. Панамын засгийн газраас 2002 оны 1-р сард мэдээллийн хууль батлан гаргасан. Гэтэл удалгүй мөнөөх засгийн газраас мэдээлэл хүсч буй тухайн хувь хүн ямар учраас мэдээлэл авах тухай үндэслэлээ гаргах шаардлагатай байх журмыг батлан гаргасан нь тус хуулийн эсрэг санаатайгаар зөрчил үүсгэсэн асуудал болсон. Гэхдээ энэ асуудлыг шинэ ерөнхийлөгч сонгогдон гарсаны дараагаар хүчингүй болгосон.

Нууцлах сэтгэлгээ, уламжлалт хандлага

Нээлттэй байх соёлыг хөгжүүлэх нь хүндрэлтэй байдаг. Албаны хүмүүст байгаа мэдээлэл нь нийтэд мөн хүртээмжтэй байх бөгөөд иргэд тэрхүү мэдээллийг авах эрхтэй гэдгийг төрийн албаныхан ойлгон, өөрсдийнхөө бодол санааг өөрчилж сурах хэрэгтэй байдаг. Иймэрхүү бодол, санаа нь ямарч бус, хууль эрх зүйн тогтолцоонд онцгой зүйл бус боловч шийдвэрлэгдэхэд олон жил шаардагддаг. МЭЧ-ний хуулийг хамгийн түрүүнд хэрэгжүүлсэн Канад, Австри зэрэг улсууд одоог хүртэл хорин жилийн турш энэхүү асуудлын эсрэг тэмцээр байна.

Мөн ил тод нээлттэй хэмээх сэтгэлгээг төлөвшүүлэхэд саад болдог зүйл нь олон нийтийн ойлголт муу эсвэл үл тоосон байдалтай холбоотой. Хэрэв олон нийт мэдээллийг эрэлхийлэхгүй бол төрийн байгууллагууд санаачлага гарган тохиромжтой загвар болон үйл ажиллагааг бий болгож хариуцлагатай хандахгүй юм. Боснид л гэхэд дэлхийн хэмжээнд хамгийн сайн хийгдсэн хэмээн тооцогддог хуулийг бараг л ашиглахгүй байгаа хэмээн үзэж болно. 2005 онд Косовад тус улсын омбудсмен тайлагнаж байгаагаар ямар ч хүмүүсээс санал гомдол хүлээн аваагүй. Харин Албани улсад л гэхэд ийм хууль байдаг гэдгийг төрийн албаны хүмүүс ч, иргэд ч сайн мэддэггүй учир мөн л ашиглагдах нь ховор. Түүнчлэн хууль бий болоод удсан орнуудад ч хүртэл хүний эрхийг хамгаалах асуудал хөндөгдөн гардаг. Швед Улсад 2002 оноос эхлэн төрийн байгууллагуудын ил тод байдлыг нэмэгдүүлэх, мэдээллийг ил болгох бодлогын талаар нийтийн мэдлэг, мэдээллийн түвшинг дээшлүүлэх, иргэдийн оролцоог идэвжүүлэх зорилгоор “Нээлттэй Швед” компани ажил зохион байгуулан ажиллаж байгаа. Удаан хугацааны туршид мэдээллийн эрх чөлөө оршин тогтнож байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтийн сул байдал, иргэдийн өөрсдийнхөө эрхийн талаарх мэдлэг дутуу байгаагаас холбогдох асуудлууд үүсч байна хэмээн тус улсын засгийн газрын зүгээс

мэдэгдэж байна⁵¹. 2001 онд Норвеги Улсад омбудсмен МЭЧ-ний хэрэгжилтийг системтэйгээр шалгаад дараах дүгнэлтэнд хүржээ: Мэдээллийн эрх чөлөөний хууль батлагдаад 30 жил өнгөрч байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтэд нэмэлт сайжруулалт хэрэгтэй байгаа болон үүнийг олонд ил болгохтой холбоотой асуудал санал хүсэлтүүдээс харагдаж байна. Мэдээллийн эрх чөлөөг нэмэгдүүлэх талаар хянамгай, тууштай ажиллах нь маш чухал бөгөөд ил болгох үйл ажиллагааг улам нэмэгдүүлэх чиглэлийг баримтлах ёстой.

Мэдээллийг хугацаандаа өгөхгүй байх

Мэдээллийг хугацаандаа өгөхгүй байх нь мэдээлэл өгөхөөс татгалзсан гэсэн үг юм. Сурвалжлагч өөрийн нийтлэлдээ орох мэдээлэл шаардах, иргэд өөрсдийнх нь ойр орчинд нөлөөлөх төслийн талаар мэдээлэл авах хэрэг гарна. Хэрэв мэдээлэл цагтаа ирэхгүй бол төсөл иргэний ямар ч судалгаа, шинжилгээгүйгээр хийгдэх болдог.

Ерөнхийдөө, МЭЧ-ний тухай хууль нь төрийн байгууллагууд хүсэлтэд аль болох түргэн буюу хамгийн их гэхэд хоёроос гурван долоо хоногийн дундаж хугацаанд багтаан хариу өгч байх шаардлагыг тавьдаг. Жижиг улс орнуудад болон ийм төрлийн хууль нэлээд хэдэн жилийн хугацаанд хэрэгжсэн газруудад тухайн байгууллага маш бага хугацаанд (24 цагийн дотор) хариу өгөх, холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Ихэнх байгууллагын хувьд аман хүсэлтийг хүлээн авдаг бөгөөд боломжтой бол тэр дор нь хариу өгөх ёстой. Нэмэлт хугацаа шаардах шалтгаан нь мэдээлэл авах тухайн хүсэлт их хэмжээний, нарийн төвөгтэй, түүнчлэн хүсэлттэй холбоотой мэдээллийг өөр байгууллага эзэмшдэгтэй бол гарч болно. Ихэнх байгууллагуудын хувьд хуулийн заасан хугацаанд тухайн хүсэлтэд хариу өгөх тал дээр асуудалтай байдаг. Эдгээрээс АНУ хамгийн томоохон зөрчил гаргагч орон юм. Зарим тохиолдолд хүсэлтийн хариуг хэдэн жилээр тэр бүү хэл хэдэн арван жилээр хүлээх тохиолдол байдаг. Үндэсний аюулгүй байдлын архиваас хамгийн удаан хугацаанд хүлээгдэж байгаа хүсэлт нь 17 жил болж байжээ.

Их Британи улсын хуулиар хариу өгөх хугацааг тодорхой тогтоож өгдөггүй, буюу албаны хүмүүс нийтийн санал гомдол харгалзан үзэх, сорил явуулах ажилд хугацаа заадаггүй. Ингэснээр тухайн гомдол саналд илүү урт хугацааны саатал гарах, албаны хүмүүс хугацаанд нь хариу өгөхөөс зайлсхийх боломжийг бүрдүүлдэг.

Эх сурвалж дутагдалтай байх нөхцөлд гомдол өргөдөл гаргах түвшинд ч асуудлууд гардаг. Их Британий мэдээллийн хороо хүмүүсээс ирсэн 1000 гаруй өргөдөлд дарагдаад байгаа бөгөөд түүнд хариу өгөхөд 12 сараас илүү хугацаа зарцуулах шаардлагатай болох болно.

Саатлаас зайлсхийх хамгийн оновчтой арга зам бол тухайн хүсэлтэд аль болох түргэн буюу тэр даруй хариу өгөх явдал юм. Тухайн саналд хэтэрхий удаан хугацааны саатал учруулах нь бэлэн байгаа мэдээллийг хүсэлт гаргагчид өгөх МЭЧ-ний гол утга санааг алдагдуулдаг. Жишээлбэл: бусад зөвлөх үйлчилгээ болон шийдвэр гаргах үйл явцад хариу даруй өгөх шаардлагатай юм. Түүнчлэн хамгийн сүүлийн судалгаанаас хархад төрийн байгууллагуудад хариу өгөх эцсийн хугацааг хэдий чинээ богино тогтооно, саатал гарах магадлал тэр хэмжээгээр бага байдаг нь тогтоогдсон. Энэ байдал нь тухайн байгууллага аливаа өөрийн үйл ажиллагаанууддаа буюу хүсэлтүүдэд хариу өгөх ажилдаа тэргүүн ач холбогдол өгдөгтэй холбоотой⁵².

⁵¹ Ханс Сандстром, Нээлттэй Швед Ажиллагаа (2003).

⁵² Нээлттэй Нийгэм Хуулийн Санаачлага Хөтөлбөр, Мэдээллийн хяналт шинжилгээний хэрэгслийг ашиглах боломж: 5 орны туршилтын үйл ажиллагааны тайлан. 2004 оны 9 дүгээр сар http://www.justiceinitiative.org/db/resource2/fs/?file_id=14972

Гэхдээ энэ асуудал ихэнх байгууллагуудын хувьд нэлээд хүндрэлтэй байдаг. Төрийн байгууллагуудыг хангалттай хэмжээний нөөц, эх сурвалжаар ханган өгснөөр тухайн байгууллага мэдээлэл боловсруулах, хүсэлтэд хариу өгөх боломжтой болдог. МЭЧ-ний тухай хуулийн хэрэгжилт, Үйл ажиллагааны урт хугацааны туршлагаас үзэхэд дээрх асуудлууд бүрэн шийдэгдээгүй байна. Ингэснээр иргэд хуулийн үр нөлөөтэй байдалд үл итгэх байдлыг төрүүлэхэд нөлөөлж байна.

Төлбөр

МЭЧ-ний олон хуулиудад төрийн байгууллагууд мэдээлэл хүссэн хүмүүсээс төлбөр авах явдлыг зөвшөөрсөн байдаг. Өргөдөл гаргах, хувилах, хайлт хийх болон шүүхэд хандах зэрэгт төлөх төлбөрүүд түгээмэл хэлбэр нь юм. Төлбөр төлөх нь их маргаантай асуудал юм. Төлбөртэй байгаа нь амьжиргааны түвшин доогуур эмзэг бүлгийн хүмүүсийн төрийн байгууллагаас мэдээлэл авах чадамжийг хязгаарлаж байна. Ирландад өргөдөл гаргах, шүүхэд хандахад төлбөр төлдөг болгосноор хүсэлтийн тоо 50 хувь буурч байсан байна. Японд төрийн байгууллагууд нэг удаагийн хүсэлтийг олон хандалттай болгосноор тэрхүү үйлчилгээний төлбөр хүсэлт гаргаж буй дундаж хүмүүсийнхээс хол давж өссөн байна. Төлбөртэй болгосноор зардлыг нөхөх механизм бий болгох бус ирэх санал хүсэлтийн тоог бууруулах захиргааны саадыг бий болгодог. Энэтхэгт маш олон байгууллагууд банкны лавлагааг шаарддаг бөгөөд төлбөртэй холбоотой чирэгдэл ихтэй журмуудаас болоод энэ лавлагааг гаргуулах зардал нь оролцох боломжийг нээж өгөх хүсэлтийг нь хүлээн авах эсвэл буцаах материалыг бүрдүүлэх зардлаас даруй 2 дахин их болдог байна.

Төлбөр, хураамжийг урвуулан ашиглах тал байдаг. Канадад мэдээлэл авах хүсэлтийг нь хүлээж аваад тэр мэдээллийг нь өгөхөөсөө өмнө ихээхэн хэмжээний төлбөр шаарддаг нь хүсэлт гаргасан хүний хувьд чамгүй сорилт болдог. Үүнээс шалтгаалаад төлбөр эсвэл хуулийн туслалцаа авсаныхаа хөлсийг төлөх чадвартай хүмүүс нь мэдээлэл авах эрхээ хангахын тулд өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй тэрхүү зардлыг төлөх тэр сорилтыг давах болж байна. 2006 онд Мэдээллийн Коммисын тэргүүн өөрт буй программыг ашиглаад богино хугацааны дотор олоод авчиж болох мэдээллийг авах хүсэлт тавиад \$1.6 саяыг төлөхийг шаардахад нь Засгийн газрыг шүүмжилсэн байдаг. Австралид Холбооны нэгдсэн улсын хуулийн шүүхэд хандах төлбөр нь маш өндөр байдгаас цөөхөн хэдэн хүн л энэ үйлчилгээг авч чаддаг байна. Амьдрал дээр хуулийн байгууллагууд төлбөртэй байхыг зөвшөөрдөг, мэдээлэл өгөх нэрлэсэн зардал нь төлбөрийг хурааж, зохих бүртгэл тооцоог хийхтэй холбоотой захиргааны зардлаас бага байдаг тул олонхи хүсэлтийн хувьд төлбөрийг заавал төлүүлэх шаардлага тавигддаггүй. Төлбөрийн хэмжээг тогтоох хамгийн сайн арга зам гэвэл чөлөөлөх заалтад хамаарагдах, иргэдийн эрх ашигтай холбоотой мэдээлэлд хөнгөлөлт үзүүлэх, шүүхэд хандаж байгаа хүсэлтийг төлбөртэйгээр хүлээж эсэхийг шийдэхэд зарцуулсан цагаар бус харин харин мэдээлэл өгөх бодит зардлаас давуулахгүй байх явдал юм. Хуулийн байгууллагын бүхий л түвшинд баримтлах нэг ерөнхий зарчим бол аливаа төлбөр саад тотгор учруулах эсвэл ашиг олох хэрэгслэл биш байх явдал юм.

Бүртгэлийн зохион байгуулалт

Бүртгэлийн үр дүнтэй зохион байгуулалт, мэдээллийн эрх чөлөөний үр дүнтэй байдал хоёрын уялдаа холбоо нь маш ач холбогдолтой. Мэдээллийн эрх чөлөөг бодитой хэрэгжүүлэхийн тулд мэдээллийг цуглуулах, индексжүүлэх, хадгалахад дөхөмтэй болгосон бүртгэлийн систем бүрэлдэн хэвшсэн байх ёстой. Олон орнуудад бүртгэлийн систем хангалтгүй байдгаас мэдээлэл олж авах чармайлт, санаачлагад ноцтой саад болж байдаг. Канадын Мэдээллийн Комиссын 1999-2000 оны жилийн тайланд дурьдахдаа:

Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн бүрэн хөтөлбөрийн үндэс суурь нь мэдээллийг бүртгэлд оруулан, зүй ёсоор индексжүүлэн, эмхлэн эрэмбэлж, олоход дөхөмтэй болгох, зохих журмын дагуу архивлах, үнэтэй мэдээллийг алдахаас хамгаалахын тулд устгахын өмнө маш анхааралтай

үзэж, танилцаж, үнэлгээ өгөх явдал юм. Тухайн сэдвээр байгаа мэдээллийн бүртгэл хийгдээгүй эсвэл тэдгээр мэдээлэл хаана байгаа эсвэл хаанаас олж, бэлэн болгохыг шууд мэдэхгүй байгаа бол мэдээлэл авах эрхийн утга учир алдагдана. Мэдээлэл авах боломжид тийм их эрсдэлтэй зүйл байхгүй. Бид түүхээ хадгалж, тэмдэглэж, түүнээсээ суралцах чадвартай байж хэмээнэ улс, үндэстэн байна. Манай төр иргэдэдээ сайн засаглалыг хүргэх чадвартай байж хэмээнэ оршин тогтноно⁵³.

Сүүлийн 10 жилд бий болоод байгаа нэг шинэ асуудал бол цахим мэдээллүүдийг хэрхэн хадгалж, хамгаалж, яаж харьцах вэ гэдэг асуудал. Засгийн газрууд тэдгээр цахим шуудан болон эрэмбэлэгдэн эмхлэгдсэн мэдээллийг цэгцлэх, эргэлтэд оруулах дүрэм журмыг тогтоох арга зам хайж байна. Түүний цаана энэхүү мэдээллүүдийг ирээдүйд яаж ашиглаж байх вэ гэдэг асуудал гарч байна. Шинэ шинэ программууд бий болж, өөрчлөлт гарч байгаа болохоор диск болон файлуудыг ирээдүйд унших боломжтой байхын тулд нэгдсэн стандарт бий болгох эсвэл компьютерийн хуучин системүүд болон программуудыг хэвээр хадгалах зайлшгүй шаардлагатай. Саяхнаас нилээд хэдэн орны засгийн газрууд ирээдүйн үеийнхэн цахим файлуудыг үзэх боломжийг бүрдүүлэх үүднээс документуудын нээлттэй стандартыг мөрдөх талаар анхаарах боллоо. Австралийн Үндэсний архив ирээдүйн материалуудыг хадгалахын тулд Опен документ стандарт буюу документийг нээх форматыг авч ашиглаж байгаагаа 2006 онд зарласан байна.

Улсын Нууцын Тухай Хуулиуд

Улс орон болгонд үндэсний аюулгүй байдалтай холбоотой маш эмзэг нууц мэдээллүүд байдаг бөгөөд тэдгээр мэдээллийг тодорхой хугацааны турш нууцлалыг нь хамгаалах шаардлагатай байдаг. Ихэнх улс гүрэн энэхүү нууццыг хамгаалах хууль дүрэмтэй байдаг. Үүнээс нууцын хууль мэдээллийн эрх чөлөөний хооронд байнгын зөрчил үүсэж байдаг юм. Нууцын хамгаалалтын хүрээ өргөн байх тусмаа улсын нууц гэсэн шалтгаар хүний түгээмэл эрхийг зөрчиж, ардчилалд, зарим нь бүр хэдэн зуун жил оршин тогтнож ирсэн ардчилалд заналхийлэх вий гэж санаа зовох асуудлыг үүсгэдэг.

Мэдээллийн эрх чөлөөний хууль болгон үндэсний аюулгүй байдлаас шалтгаалан мэдээлэл өгөхгүй байх/чөлөөлөх тухай тусгай заалт эсвэл өөр нэгэн хуулийг иш татан оруулсан байдаг. Нууц Мэдээллийг Хамгаалах Актууд нь нууц мэдээллийг хэрхэн бүртгэх, хамгаалах, нууц мэдээллийг ашиглах болон гаргах журмуудыг нарийвчлан заасан байдаг. Мэдээллийг тусгай зөвшөөрөлгүйгээр дэлгэхийг хориглосон Албан Ёсны Нууцын Акт болон гэмт хэргийн заалтууд, тагнуулын болон батлан хамгаалах байгууллагуудыг байгуулах тухай органик актууд, хуучны нууц цагдаагийн газрын архивийг ашиглах тухай тусгайлан гаргасан хуулиуд нууц мэдээллүүдийг хамгаалж байдаг.

Мэдээлэл авах боломжийг бүрдүүлэхэд эдгээр хуулиуд ихээхэн бэрхшээл учруулдаг. Хамтын Нөхөрлөлийн ихэнх орнуудад Британийн Колонийн үеийн Албан Ёсны Нууцын Акт одоо болтол хүчинтэй хэвээр байна. Зүүн Европ, Төв Азид Зөвлөлтийн үеийн цагдаагийн албад бараг ямар ч өөрчлөлтгүйгээр үйл ажиллагаа явуулсан хэвээр байгаа юм. Төв Европын орнууд НАТО-д элсэн орсноор хуучин Зөвлөлтийн үеийнхээс харьцангуй дээр Нууц Мэдээллийн Хуулийг мөрдөх болсон нь мэдээллийн эрх чөлөөний бодлогыг саармагжуулж байна. Нэгэн цагт нээлттэй нийгмийн билэг тэмдэг байсан АНУ “Терроризмтой Зарласан Дайн”-ы улмаас мэдээлэл авах эрхэнд шинэ хязгаарлалт хийлээ.

Сүүлийн хэдэн жилд энэ зөрчилдөөн улам газар авах боллоо. Финланд, Эстони, Латви улсын тэргүүн нар эсвэл томоохон албан тушаалтангууд улсын нууцыг буруу ашигласан эсвэл нууцтай буруу харьцсан гэдэг шалтгаанаар огцорчээ. Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл

⁵³ Канадын Мэдээллийн Хороо, Жилийн Тайлан 1999-2000

нийтэлсэн хэвлэл мэдээллийн ажилтнуудыг Румын, Энэтхэг, Пакистан, Дани, Англи, Швейцарь улсуудад нууцын тухай акт тогтоолыг зөрчсөн хэмээн буруутгасан байна. АНУ-д буруу зүйлийг нийтэд мэдээлсэн хүмүүсийг шүүх хуралдаан, хуль бусаар даган мөрдөж, чагнасан хэргүүд, Канадын иргэнийг Сирид аваачин тамлаж байсныг улын нууцын хуульд тулгалт шахалт хийж байж л илрүүлсэн юм.

Мэдээллийн хэт нууцлал нь зарим тохиолдолд маш чухал мэдээллүүдийн хамгаалалтыг сулруулах аюултай байдаг. Нууцлалын системийг сайн зохион байгуулж чадахгүй бол хамгийн нууц мэдээ ч гэсэн гадагшаа алдагдах аюултай байдаг. 2002 онд Унгарт Ерөнхий сайд Петр Медгуессийн тагнуулын байгууллагын нэгэн хэсэгт ажилладаг байсан тухай хуучин дотоод яамны хавтаст хэргийг нийтэлсэн байна. 2005 оны 2 дугаар сард, Польшид коммунизмын үед дотоод яамны мэдээлэгч, төлөөлөгч байсан болон хохирогч нар нийт 240 мянган хүний нэрс интэрнэтээр цацагджээ.

Мэдээлэл авах боломж сайжирсан нэг зүйл бол хуучин дотоод яамны хавтаст хэргүүдтэй танилцах боломжтой болсон явдал юм. Олон тооны хуучин архивуудыг дэлгэн үзүүлэх боллоо. Ардчилалд шилжин орсноос хойш Төв болон Зүүн Европын ихэнх улсууд хуучин дотоод яамны баримтуудыг дэлгэх хуулиудыг батлан мөрдөх болжээ. Үүний үр дүнд хүмүүс дотоод яам тэдэн дээр ямар хавтас хэрэг хөтдөж байсныг мэдэх боломжтой болсон юм⁵⁴. Үүнийг хамгийн өргөн хүрээтэйгээр, нийтэд хүрэх боломжтойгоор хийсэн орон бол Герман улс юм. 1991 оноос эхлэн хуучин Зүүн Германы нууц алба Стаси-ийн архивийг хувь хүмүүс, судлаач нарын өмнө үзэх эрхийг чөлөөтэй болгожээ. Энэхүү архивийг нийтэд нээлттэй болгосноос хойш 2 сая хүн мэдээлэл авах хүсэлт гаргаж, 3 сая хүний намтрын талаар мэдээлэл авах хүсэлт ирсэн байна. Судлаачид болон хэвлэл мэдээллийнхэн архивийг 15 мянган удаа ашигласан байна. Словакт 60 мянган хавтаст хэргийг Үндэсний Дурсамжийн Институт интэрнэт дээр байрлуулсан ажээ. Чех улсад 2003 онд Дотоод Хэргийн Яамны вебсайт дээр 75 мянган нууц мэдээлэгчдийн жагсаалтыг тавьсан байна. Европын Хүний Эрхийн Шүүх холбогдох хүмүүсийн тухай баримтуудыг нийтэд дэлгэх тухай хэд хэдэн шийдвэр гаргаж байжээ. Гэхдээ, 2002 онд Болгарт хүчин төгөлдөр болсон Нууц Мэдээллийг Хамгаалах Хуулийн дагуу эдгээр баримтуудад хүрэх боломжийг хаажээ.

Хувийн Нууц

Засгийн газрууд өөрсдийн иргэдийн тухай ихээр цуглуулах болсон, мэдээллийн эрх чөлөөний хуулийг даган мөрдөх болсон нь олон улс орнуудад мэдээлэл авах эрх болон хувийн эрхийн хооронд зөрчилдөөн үүсгэх болжээ. Энэ 2 эрхийг ихэнх тохиолдолд “нэг зоосны 2 тал” хэмээн тайлбарладаг. Энэ 2 эрх нь бие биенийгээ нөхөн гүйцээсэн мөртлөө бие биетэйгээ зөрчилддөг чанарыг хоёуланг нь шингээсэн эрхүүд хэмээн тайлбарлвал илүү зохимжтой байх болов уу.

Төрийн мэдэлд байгаа мэдээллийн сангаас хувь хүний талаар мэдээлэл авах гэсэн хүсэлт гаргах үед энэ 2 эрх зөрчилдөөнд ордог. Нөгөө талаар энэ хоёр эрхийн тусламжтайгаар хувь хүн өөрийн талаарх мэдээллийг авч засгийн газрыг хариуцлагад татах эрхтэй болдог юм. Унгар улсын Мэдээллийн Эрх Чөлөө болон Мэдээлэл Хамгаалах анхны дарга Ласло Мажтэнью хэлэхдээ энэхүү 2 эрхийн нийтлэг зорилго бол “мэдээллийн хувьсгал болсон ертөнцөд иргэдийн нууцыг хадгалахын сацуугаар төрийг улам нээлттэй ил тод болгох явцыг⁵⁵” хэвээр нь үргэлжлүүлэхэд оршино гэж хэлсэн байдаг.

⁵⁴ Унгар, 1994 оны XXIII Акт, Дээд албан тушаалтан, Төрийн албан хаагчдыг шалгах, <http://www.th.hu/html/en/torv.html>; Литва, Хуучин ЗХУ-ын тусгай албадуутай нууцаар хамтран ажиллаж байсан хүмүүсийг бүртгэх, мэдүүлэг авах, бүртгэх, хамгаалах тухай хууль No. VIII-1436. 1999 оны 11 сарын 23, 1999. 2000 оны 6 сарын 13 аас хэрэгжиж эхэлсэн No. VIII-1726. <http://www3.lrs.lt/cgi-bin/getfmt?c1=w&c2=123807>

⁵⁵ Доктор Ласло Мажтэнью, Мэдээллийн эрх чөлөө, Унгарын Загвар (2002)

Бүхий л мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиуд нь хувийн нууцтай холбоотой мэдээллийг хамгаалах, чөлөөлөх заалттай байдаг. Түүний хажуугаар ихэнх орнууд төрийн болон хувийн хэвшлийн мэдэлд байгаа хувь хүнтэй холбоотой мэдээллийг хамгаалах хуулиудыг батлан мөрдөж байдаг юм. 50 гаруй оронд эдгээр хуулиуд нь өргөн хүрээтэй төр ба хувийн хэвшлийг хоёуланг нь хамарсан хэлбэртэй байдаг. Тухайн салбараас шалтгаалан, зөвхөн тухайн салбарт зориулан баталсан цагдаа, эмнэлэг гэх мэт зориулалттай хуулиуд байдаг⁵⁶.

Хувийн нууц гэдэгт чухам ямар мэдээллийг хамруулах вэ гэдгийг нарийвчлан заагаагүй, заасан ч ихээхэн бүрхэг байдаг нь мэдээллийн эрх чөлөөний хууль болон мэдээлэл хамгаалах Актүүдын хооронд зөрчилдөөн гарахад хүргэдэг юм.

Албан хаагчид хувь хүн гэсэн үг л байх юм бол ямар ч утгатай байхыг үл хайхран хувийн нууц гэдэг үндэслэлээр мэдээлэл өгөхгүй байх явдал байна. АНУ гэхэд л алан хядах үйл ажиллагаанд оролцсон хэргээр сэжиглэгдсэн хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хувийн нууц гэдэг үндэслэлээр өгөхгүй байх явдал тэмдэглэгдсэн билээ. Энэ хүмүүсийн ихэнх нь удаан хугацаагаар, нууцаар хоригдож хуулиар хамгаалуулах эрх нь алдагдаж бйасан юм. Холбооны шүүхээс засгийн газрын мэдээлэл өгөхөөс татгалзсан шалтгааныг 2006 онд үндэслэлгүй гэж үзэн хүчингүй болгосон билээ. Японд хувийн нууцыг хамгаалах шинэ хуулийг төрийн албан хаагчийн тухай мэдээлэл авах гэхэд урвуулан ашиглаж байсан тохиолдол илэрчээ. 1970 оноос хойш Испанид дүрвэн амьдарч байсан Хаан (одоо ерөнхий сайд) Симеон Сакс-Кобурготагийн талаар мэдээлэл авахыг Болгар улс хүсэхэд татгалзсан учир хоёр улс харилцаагаа түр таслаад байна. Их Британид Парламентын гишүүдийн замын зардал болон аяллын талаар мэдээлэл өгөхийг хориглодог. Шинээр гарсан Өмнөд Африкийн PAIA гэх мэтийн хуулиуд хувийн нууцтай холбоотой мэдээлэл гэж юуг хэлэх вэ гэдэг дээр илүү нарийн тодорхойлолт гаргаж ирэх боллоо. Зарим хуулиуд нийтийн эрх ашгийн сорилоор энэ асуудлыг шийдэж байна. Олон орны шүүх, мэдээллийн хороонууд төрийн албан хаагч ажлын шугамаар хэнтэй уулзсан, юу хийсэн бэ гэдэг нь хувийн нууц биш хэмээн дүгнэлт гаргасан байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн 10 жилийн хугацаанд мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай болсон орнуудын тоо эрс нэмэгдэж байна. МЭЧ -ний хууль дэлхийн улс орнуудад түгээмэл болж байна. Үйл ажиллагаа, чиг үүргээ сайжруулахын тулд Мэдээллийн Комисс зэрэг оролцоо хэмжүүрүүдийг хуулиудад бий болгож, шинээр гаргаж байна. НҮБ–н Авилгалын эсрэг Конвенци зэрэг олон улсын гэрээ хэлэлцээрүүд, хариуцлагын тогтолцоог илүү сайжруулах болон олон нийтийн оролцоог дэмжих талаар гарч байгаа олон улсын болон үндэсний хэмжээний хэрэгцээ шаардлагаас үүдэн олон олон улс үндэстэнүүд ийм хуультай болох гэж байна.

Гэхдээ энэ чиглэлээр хийх зүйл их байна. Нээлттэй байдлыг соёл болгон хөгжүүлж, хэвшүүлэх нь олон олон улс орны хувьд төвөгтэй хэвээр байна. Сул хууль, хэрэгжилт, хяналт нь олон улс орны хувьд хүчин чармайлтыг хаан боогдуулж, саад учруулан мэдээлэл авах боломжийг бүрэн олгохгүй байна. АНУ зэрэг бусад орны хувьд мэдээллийн хүртээмжийн эсрэг байр суурь олон зууны настай мэдээлэл авах эрхийг багасгаж байна. Шинээр энэ хуультай болж байгаа орнуудад мэдээллийн бүртгэл хангалтгүй түвшинд байна. Төрийн нууц болон хувийн нууцыг хадгалах явдлыг урвуулан ашиглах явдал гарсаар байна.

⁵⁶ EPIC(Электрон Ертөнц дэх Хувийн Нууцын Төв) болон Прайвэси Интэрнэционал, Хувийн Нууц болон Хүний Эрх 2005 (EPIC, 2006) Вэбсайт <http://www.privacyinternational.org/survey/>. Дэлхийн Мэдээлэл Хамгаалах Хуулиуд <http://www.privacyinternational.org/survey/dpmap.jpg>